



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын гуравдугаар хавсралтын 3, 14 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл” сэдэвт нийцлийн аудитын (НТАГ-2026/14-11/ШТА-НА) тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

2.Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, үр дүнг 2027 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбат, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Т.Оюунчимэг нарт зөвлөсүгэй.

3.Нийцлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2027 оны 2 дугаар улиралд танилцуулахыг Гүйцэтгэл, нийцлийн аудит хариуцсан Ахлах менежер (Ч.Болд)-т үүрэг болгосугай.

4.Тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид тус тус хүргүүлсүгэй.



Г.НАНДИНЖАРГАЛ

1426010019



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

Аудитыг гүйцэтгэсэн:	ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	1
	ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
	ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	2
	ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	2
	ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	2-3
	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ	4-5
Нийслэл дэх Төрийн аудитын газрын	ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6-7
Гүйцэтгэл, нийцлийн аудит хариуцсан ахлах менежер Ч.Болд	Бүлэг 1. Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн байна уу?	8
	1.1 Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актууд холбогдох хууль тогтоомжтой нийцэж байна уу?	8
Нийцлийн аудитын алба	1.1.1 Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжууд хоорондоо нийцэж байна уу?	8-9
	1.1.2. Холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэрүүд хууль тогтоомжтой нийцэж байна уу?	9-11
Аудитын менежер Б.Золбаяр	1.2. Төрийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтэц бүрдсэн байна уу?	11
Ахлах аудитор 3.Баярбилэгт	1.2.1. Төрийн сангийн үйл ажиллагааг явуулж буй бүтэц, зохион байгуулалт оновчтой байна уу?	11-13
Аудитор	1.2.2. Төрийн сангийн албан хаагчдын гүйцэтгэж буй чиг үүрэг давхардалгүй, ажлын байрны тодорхойлолттой нийцэж байна уу?	13-16
	1.2.3. Төрийн сангийн цахим системийн удирдлага, зохицуулалт, мэдээллийн аюулгүй байдал нь холбогдох хууль тогтоомж, стандартад нийцэж, хэрэгцээ шаардлагыг нь бүрэн хангаж байна уу?	16-18
	Д.Зэндмэнэ	Бүлэг 2. Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байна уу?
	2.1 Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт батлагдсан төсөв, төсвийн хуваарь, хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байна уу?	19
	2.1.1. Төсвийн санхүүжилтийн эрх олголт нь батлагдсан төсвийн хуваарь, хууль тогтоомж, холбогдох баримт бичгийн шаардлагад нийцэж, хугацаанд нь олгогдож байна уу?	19-21
	2.1.2. Төсвийн зарцуулалтын эрх олголт нь батлагдсан төсөв, зориулалт, эдийн засгийн ангилал болон шаардлагад нийцэж хэрэгжиж байна уу?	21-22
	2.2. Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагаа хууль, журмын дагуу баталгаажин, нэгдсэн хяналттайгаар хэрэгжиж байна уу?	22-23
	2.2.1. Төв төрийн сан нэгдсэн данс, бүртгэлийн дансны төлбөр тооцоо, гадаад валют, үлдэгдэл, баталгааг хугацаандаа холбогдох системд бүртгэх, Монгол банк дахь төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэлтэй тулган баталгаажуулж, зөрүүг тухай бүр залруулах арга хэмжээ авч байна уу?	23-25



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

2.2.2. Төрийн сан, төсвийн байгууллага бүртгэлийн дансны төлбөр тооцоо, төлбөрийн хүсэлт, зарлагын гүйлгээг хийхдээ эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдэг, үндэслэх баримт бичиг, мэдээллийг үнэн зөв бүрдүүлж, зориулалт, ангиллын дагуу гүйцэтгэсэн үү?	25-26
2.2.3. Төв төрийн сан, бүртгэлийн дансны тодорхойгүй орлого, буцаалтыг журмын дагуу дансанд байршуулж, холбогдох баримтыг үндэслэн гүйлгээг залруулан буцааж байна уу?	26-27
2.2.4. Төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсөв хоорондын тооцоо болон холбогдох тохируулгын тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, тайлагнаж байна уу?	27-28
2.3. Төрийн сангийн үйл ажиллагаа, хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?	28-29
2.3.1. Төрийн сангийн төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус дотоод хяналтыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу тогтмол хэрэгжүүлж, тайлан гаргаж, удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээ авч ажилласан уу?	29-30
2.3.2. Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг зааврын дагуу үнэлсэн мөн өдөр тутмын дотоод хяналтыг бүх шатны төрийн сангийн үйл ажиллагаанд батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу тогтмол хэрэгжүүлж, тайлагнан удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан уу?	30-31
2.3.3. Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?	31
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ	32
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР	33
АУДИТЫН ДҮГНЭЛТ	34
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	35
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө “Г” корпус, Утас: 70007734	
Тайланг http://audit.mn/ НТАГ-ын веб сайтаас үзнэ үү.	
ХАВСРАЛТ	36-45



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үгс	Тайлбар
АТТ	Албан тушаалын тодорхойлолт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БОНХС	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
БХД	Багахангай дүүрэг
ЗГ	Засгийн газар
ЗГСУМС	Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн систем
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
КАБТХ	Кибер аюулгүй байдлын тухай хууль
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
МУНУБХЭЗБТХ	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
НД	Налайх дүүрэг
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
САА	Санхүүгийн аудитын алба
СБД	Сүхбаатар дүүрэг
СС	Сангийн сайд
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СХОГ	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
СЯ	Сангийн яам
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТАТХ	Төрийн албаны тухай хууль
ТСГ	Төрийн сангийн газар
ТСҮАЖ	Төрийн сангийн үйл ажиллагааны журам
ТТХ	Төсвийн тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Нийслэл, дүүргүүдийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, санхүүжилт олгосон дүн	6
Хүснэгт 2	Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжийн 2023-2025 оны үйл ажиллагааны үзүүлэлтүүд	7
Хүснэгт 3	ТТХ-д заасан төрийн сангийн нийтлэг чиг үүрэг болон ТСҮАЖ-ын уялдаа	9
Хүснэгт 4	Албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангасан байдал	15
Хүснэгт 5	Томилогдсон албан тушаалаас бусад чиг үүргийг хавсран гүйцэтгэж байгаа албан хаагчдын мэдээлэл	15-16
Хүснэгт 6	Нийслэл, дүүргүүдийн батлагдсан төсөв	19-20
Хүснэгт 7	Батлагдсан төсвийн гүйцэтгэл, зөрүү	21
Хүснэгт 8	Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжийн 2023-2025 оны үйл ажиллагааны үзүүлэлтүүд	23-24
Хүснэгт 9	Нийслэлийн гадаад валютын данс болон уг данстай холбоотой ашиглагддаг бусад дансны мэдээлэл	24
Хүснэгт 10	Нийслэлийн гадаад валютын гүйлгээ	25
Хүснэгт 11	Буцаасан гүйлгээний мэдээлэл	26
Хүснэгт 12	Залруулсан гүйлгээний мэдээлэл	27
Хүснэгт 13	Төрийн сангийн нэгжид дээд шатны байгууллагаас санхүүгийн дотоод хяналт хэрэгжүүлсэн байдал	29

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Гарчиг	Хуудас
Дүрслэл 1	Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжийн 2025 оны бүтэц, орон тооны хураангуй мэдээлэл	7
Дүрслэл 2	Нийслэл, дүүргүүдийн СТСХ-ийн бүтэц	10
Дүрслэл 3	Нийслэл болон нийслэлийн ЗДТГ-ын стратеги төлөвлөгөө	13
Дүрслэл 4	АТТ-д заасан чиг үүргийн харьцуулалт /бага, дундаж, их/	13
Дүрслэл 5	Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой зарим системүүд	17
Дүрслэл 6	Төрийн сангийн цахим системийн талаар авсан судалгааны нэгтгэл	18
Дүрслэл 7	Төрийн сангийн төлбөр тооцооны өнөөгийн байдал	23

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Гарчиг	Хуудас
График 1	Санхүүжилтийн эрх олгох хүсэлт болон гүйцэтгэлийн мэдээлэл	20

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Дүүргүүдийн ЗДТГ-ын бүтэц баталсан захирамж (2023-2025)	36
Хавсралт 2	Нийслэл, дүүргийн СТСХ-т хамаарах байгууллага, тэдгээрийн данс болон гүйлгээний мэдээлэл	36-37
Хавсралт 3	Санхүүгийн аудитаар 2023-2025 онд илэрсэн эдийн засгийн ангилал зөрчсөн зөрчил	37-39
Хавсралт 4	Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжийн 2023-2025 оны үйл ажиллагааны үзүүлэлтүүд	39-40



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

Хавсралт 5	Санхүүгийн аудитаар 2023-2025 онд илэрсэн анхан шатны баримтын зөрчлийн нэгтгэл	40
Хавсралт 6	Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжээс буцаасан гүйлгээ	40-41
Хавсралт 7	Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжээс залруулсан гүйлгээ	42-43
Хавсралт 8	Нийслэл, дүүргийн төсвийн шууд захирагч нар 2023-2025 оны гүйцэтгэлийн мэдээг төсвийн захирагч нарт хүргүүлсэн байдал /сараар/	43
Хавсралт 9	Нийслэл, дүүргийн төсвийн захирагч нар 2023-2025 онд дээд шатны байгууллагад гүйцэтгэлийн мэдээг хүргүүлсэн байдал /сараар/	43
Хавсралт 10	Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслийн гүйцэтгэлийн мэдээг хүргүүлсэн байдал /сараар/	43-44
Хавсралт 11	Нийслэл, дүүргийн төсвийн захирагч нар 2023-2025 онд ОНХС-ын хөрөнгөөр санхүүжиж буй ТАХ-ний хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад хүргүүлсэн байдал /хоногоор/	44
Хавсралт 12	Төрийн сангийн нэгжүүдээс 2023-2025 онд хяналт, шалгалтын биелэлтийг хүргүүлсэн байдал	44-45



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь заалт, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, МУЕА-ын 2025 оны “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаал, НТАГ-ын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэв.</p>
Аудитын зорилт	<p>Нийцлийн аудитыг нэгдсэн удирдамжийн дагуу нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжийн тогтолцоо болон тэдгээрийн мөрдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.</p> <p>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">✓ Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх;✓ Төрийн сангийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ	<p>Аудитад Төсвийн тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах нийслэл, дүүргийн ЗДТГ-ын харьяа төрийн сангийн нэгжүүдийн 2023–2025 оны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа болон цахим системийн ашиглалтын байдлыг түүвэрт хамруулж, дээрх хугацаанд НТАГ-аас гүйцэтгэсэн санхүүгийн аудитын тайлангаар баталгаажсан зөрчлүүдийг аудитын тайланд тусгав.</p> <p>АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан “АДБОУС-100”, “АДБОУС-400”, “АДБОУС 4000–4899”, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, мөн МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-д нийцүүлэн аудитын зорилт болон асуудлын шинжилгээний асуултад хариу өгөхөд шаардлагатай нотлох зүйлсийг холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга болон лавлагаа авах, шаардлагатай тохиолдолд тодруулга авах, судалгаа хийх, цуглуулсан мэдээллийг харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аргуудаар цуглуулж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	<p>Дараах хууль, эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашигласан. Үүнд:</p> <p>Хууль:</p> <ul style="list-style-type: none">✓ Төсвийн тухай;✓ Төсвийн тогтвортой байдлын тухай;✓ Засгийн газрын тусгай сангийн тухай;✓ Шилэн дансны тухай;✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай;✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай. <p>Засгийн газрын тогтоол:</p> <ul style="list-style-type: none">✓ Төрийн сангийн үйл ажиллагааны журам /2023 оны 444 дүгээр тогтоол/;✓ Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам /2021 оны 51 дүгээр тогтоол/;✓ Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам /2016 оны 29 дүгээр тогтоол/. <p>Сангийн сайдын тушаал:</p>



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

- ✓ Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт /2012 оны 294 дүгээр тушаал/;
- ✓ Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг заавар /2016 оны 431 дүгээр тушаал/;
- ✓ “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар”, “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал /2025 оны 112 дугаар тушаал/;
- ✓ “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар” /2024 оны 254 дүгээр тушаал/;
- ✓ Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх заавар /2024 оны 256 дугаар тушаал/;
- ✓ Төрийн сангийн цахим системийн заавар /2024 оны 255 дугаар тушаал/;
- ✓ Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх журам /2014 оны 65 дугаар тушаал/;
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам /2021 оны 86 дугаар тушаал/;

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаал:

- ✓ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам /2014 оны А-04 дүгээр тушаал/;

Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаал:

- ✓ “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам” /Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгч нар 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаал/;
- ✓ Төлбөрийн системийн журам /2023 оны А-91 тоот тушаал/.

Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг Ахлах менежер (Гүйцэтгэл, нийцлийн аудит хариуцсан) Ч.Болд хянан удирдаж, Нийцлийн аудитын албаны Аудитын менежер Б.Золбаяр үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, мөн албаны Ахлах аудитор З.Баярбилэгт, Аудитор М.Одгэрэл, Г.Саянболд, Б.Уранчимэг, Д.Зэндмэнэ нар гүйцэтгэв.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

МУЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан банк, санхүүгийн салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх зорилгын хүрээнд ЗГ-ын 2001 оны 125¹ дугаар тогтоолоор “Санхүүгийн салбарын шинэчлэлийн дунд хугацааны үзэл баримтлал”-ыг баталж, 2002 оны 101² дүгээр тогтоолоор Монгол Улсын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн албаны бүтцийг төрийн сангийн тогтолцоонд шилжүүлж, “Санхүү, эдийн засгийн яамны ТСГ”, “аймаг, нийслэл, дүүргийн засаг даргын тамгын газрын төрийн сангийн хэлтэс”, “сумын төрийн сангийн төлөөлөгч” гэсэн бүтцээр хэрэгжүүлэхээр тус тус тогтоожээ.

ТТХ-ийн 4 дүгээр зүйлд “төрийн сангийн үйл ажиллагаа”, “төрийн сангийн нэгдсэн данс”, “төсвийн ерөнхий данс” болон “зарцуулалтын эрх” зэрэг хуулийн нэр, томъёог тодорхойлж, 35 дугаар зүйлд “Төрийн сангийн нэгдсэн данс”, 36 дугаар зүйлд “Төрийн сангийн тогтолцоо”, 37 дугаар зүйлд “Төрийн сангийн нийтлэг чиг үүрэг”, 38 дугаар зүйлд “Төв төрийн сангийн чиг үүрэг”-ийг зохицуулсан байна.

Дээрх хуулийн 37.2³ дахь заалтыг үндэслэн ЗГ-ын 2012 оны 205⁴ тогтоолоор ТСҮАЖ-ыг анх баталж, 2013 оны 287⁵ дугаар, 2015 оны 24⁶, 2023 оны 444⁷ дүгээр тогтоолуудаар тус тус шинэчлэн баталсан байна.

Аудитын хамрах хугацаа буюу 2023-2025 онд Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжээс батлагдсан төсвийн хуваарийн дагуу 16,287,899.14 сая төгрөгийн гүйлгээний зарцуулалтын эрхийг нээлгүүлэхээр төв төрийн санд хүргүүлж, 13,230,560.79 сая төгрөг буюу 81.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс төсвийн байгууллагуудад 10828 удаагийн 11,645,226.37 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг хянан, баталгаажуулж олгосон байна.

Хүснэгт №1. Нийслэл, дүүргүүдийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, санхүүжилт олгосон дүн

/сая.төг/

№	Нэр	2023-2025 оны нэгтгэл			
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Санхүүжилтийн эрх	
				Тоо	Дүн
1	БНД	102,147.55	84,037.86	330	61,105.30
2	БХД	33,467.27	30,548.99	0	14,951.50
3	БЗД	1,061,939.50	865,277.81	510	444,667.44
4	БГД	823,331.95	754,648.34	935	144,427.90
5	НД	90,844.44	81,215.95	1382	60,014.49
6	СБД	1,777,577.96	1,563,797.35	1212	1,531,100.71
7	СХД	500,527.24	420,747.57	888	144,427.90
8	ХУД	1,492,258.19	1,323,604.43	471	1,322,916.10
9	ЧД	784,595.98	681,341.63	883	617,776.43
10	Нийслэл	9,621,209.05	7,425,340.84	4216	7,302,838.63
	НИЙТ	16,287,899.14	13,230,560.79	10828	11,645,226.37

Эх сурвалж: Нийслэл, дүүргүүдээс ирүүлсэн судалгааны нэгтгэл

¹ Үзэл баримтлал батлах тухай. Санхүүгийн салбарын шинэчлэлийн дунд хугацааны үзэл баримтлал;

² Төрийн сангийн тогтолцоонд шилжих тухай;

³ 37.2. Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална;

⁴ МУЗГ-ын 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 205 дугаар “Журам батлах тухай” тогтоол;

⁵ МУЗГ-ын 2013 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн 287 дугаар “Журам батлах тухай” тогтоол;

⁶ МУЗГ-ын 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 24 дүгээр “Журам батлах тухай” тогтоол;

⁷ МУЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр “Журам батлах тухай” тогтоол;



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгж 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “орон нутгийн орлого”-ын 1003, “бүртгэл”-ийн 1161, “гадаад валют”-ын 3, нийт 2,167 дансаар 785 төсөвт байгууллагад 369,898 удаагийн төлбөр, тооцооны үйлчилгээг үзүүлсэн байна.

Харин арилжааны банкинд засгийн газрын санхүүжилтийн 1, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 583, төсвийн байгууллагын 12 нийт 596 данс байна.

Хүснэгт №2. Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжийн 2023-2025 оны үйл ажиллагааны үзүүлэлтүүд

№	Огноо	Байгууллагын тоо	Дансны тоо	Гүйлгээний тоо
1	2023	750	2,228	279,381
2	2024	761	2,158	376,457
3	2025	785	2,167	369,898
Нийт				1,025,736

Эх сурвалж: Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжээс илүүсэн мэдээлэл

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2023 онд 1,017,906.07 сая төгрөг, 2024 онд 3,249,337.43 сая төгрөг, 2025 онд 2,604,681.94 сая төгрөг байна.

Аудитын хамрах хугацаанд ЗГ-ын тогтоолоор нийслэлийн ЗДТГ-ын бүтэц, орон тоог 1 удаа, нийслэлийн ЗД-ын захирамжаар дүүргийн ЗДТГ-ын бүтэц, орон тоог 2 удаа шинэчилсэн бөгөөд 2025 онд нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжүүдийг нийт 113 орон тоотой ажиллахаар батлагдаж, үүнээс 104 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, 9 орон тоо дутуу ажилласан байна.

Дүрслэл №1. Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжийн 2025 оны бүтэц, орон тооны хураангуй мэдээлэл





БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БҮРДСЭН БАЙНА УУ?

Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актууд ТТХ-тай нийцсэн, харин төрийн сангийн нэгжийн бүтэц, зохион байгуулалт нь дээрх хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-д “...дэргэд...” байх зохицуулалтын агуулгатай бүрэн нийцээгүй байна.

Нийслэлийн ЗД-ын 2025 онд А/1213 дугаар захирамжаар “*Нийслэлийн кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам*”-ыг батлан, мөрдүүлж байгаа нь сайн жишиг болжээ.

1.1. Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актууд холбогдох хууль тогтоомжтой нийцэж байна уу?

Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актууд ТТХ-тай нийцсэн боловч эрх бүхий албан тушаалтнуудын төрийн сангийн нэгжийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой шийдвэрүүдээс шалтгаалж зарим чиг үүргийн хэрэгжилт хязгаарлагдсан байна.

1.1.1 Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжууд хоорондоо нийцэж байна уу?

ТТХ-ийн Зургаадугаар бүлгийн 35 дугаар зүйлд “Төрийн сангийн нэгдсэн данс”, 36 дугаар зүйлд “Төрийн сангийн тогтолцоо”, 37 дугаар зүйлд “Төрийн сангийн нийтлэг чиг үүрэг”, 38 дугаар зүйлд “Төв төрийн сангийн чиг үүрэг”-ийг тус тус зохицуулсан бөгөөд хууль батлагдсанаас хойш эдгээр зүйлүүдэд нийт 6 удаа “нэмэлт, өөрчлөлт” оруулжээ.

Дээрх хуультай уялдуулж, төрийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор дараах эрх зүйн актуудыг баталсан байна. Тухайлбал:

Засгийн газар:

ТТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг үндэслэн 2023 оны 444 дүгээр тогтоолоор “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”,

Сангийн сайд:

- *ТТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийг үндэслэн 2012 оны 294 дүгээр тушаалаар “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”;*
- *ТТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 11.1.13, 42 дугаар зүйлийн 42.6 дахь заалтыг тус тус үндэслэн 2018 оны А/134 дүгээр тушаалаар “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”;*
- *ТТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 36 дугаар зүйлийн 36.6, 38 дугаар зүйлийн 38.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2024 оны 254 дүгээр тушаалаар “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”;*
- *ТТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 38 дугаар зүйлийн 38.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2024 оны 256 дугаар тушаалаар “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх заавар”;*
- *ТТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 22 дугаар зүйлийн 22.4, 22.7 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 112 дугаар тушаалаар “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар, Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”;*

Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгч:



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

ТТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.11, 35 дугаар зүйлийн 35.6 дахь заалтыг тус тус үндэслэн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалаар “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банкинд нээх, хаах, тайлагнах журам” зэрэг эрх зүйн актуудыг баталснаар төрийн сангийн үйл ажиллагаа явуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Мөн ЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоолоор ТСҮАЖ-ыг шинэчлэн батлахдаа ТТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан төрийн сангийн нийтлэг чиг үүргийг дараах байдлаар тусгажээ.

Хүснэгт №3. ТТХ-д заасан төрийн сангийн нийтлэг чиг үүрэг болон ТСҮАЖ-ын уялдаа

№	ТТХ-д заасан төрийн сангийн нийтлэг чиг үүргийн заалт	ТСҮАЖ-ын холбогдох хэсэг
1	37.1.1	3.9
2	37.1.2	3.3-3.7
3	37.1.3	2.4
4	37.1.4	
5	37.1.5	3.8
6	37.1.6	2.13
7	37.1.7	4.4-4.8
8	37.1.8	2.1-2.13

Эх сурвалж: Аудитын бааз

Дээр дурдсанаар төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой заавар, журмууд нь ТТХ-тай нийцэж байгаа боловч хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3⁸ болон 8.9.8⁹ дахь заалтуудын цаглабарын хугацааны зохицуулалтыг нь дүүргүүдийн түвшинд хэрэгжүүлэхэд тодорхойгүй байна.

ТТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д тайлагналын хугацаа (аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэх) болон 8.9.3-т хугацааны (нэгтгэсэн тайланг 3 дугаар сарын 05-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх) хоорондын уялдаа хангагдаагүйгээс дүүргийн харьяа хуулийн этгээдүүдийн аудитлагдсан санхүүгийн тайланг дээд шатанд хүргүүлэх, дээд шатны байгууллага нь тайланг нэгтгэж ТАБ-д хүргүүлэх үйл явц хооронд хугацааны зөрүү үүсч, хэрэгжүүлэхэд тодорхойгүй байдал бий болгож байна.

Дүгнэлт: Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актууд нь төсвийн тухай хуультай нийцсэн байна.

1.1.2. Холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэрүүд хууль тогтоомжтой нийцэж байна уу?

МУЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан банк, санхүүгийн салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх зорилгын хүрээнд ЗГ-ын 2001 оны 125¹⁰ дугаар тогтоолоор

⁸ 8.9.3.сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сан нь тухайн шатны төсвийн хагас жилийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны дотор дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх ба аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх;

⁹ 8.9.8.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

¹⁰ Үзэл баримтлал батлах тухай. Санхүүгийн салбарын шинэчлэлийн дунд хугацааны үзэл баримтлал;



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

“Санхүүгийн салбарын шинэчлэлийн дунд хугацааны үзэл баримтлал”-ыг баталж, 2002 оны 101¹¹ дүгээр тогтоолоор Монгол Улсын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн албаны бүтцийг төрийн сангийн тогтолцоонд шилжүүлж, “Санхүү, эдийн засгийн яамны ТСГ”, “аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын төрийн сангийн хэлтэс”, “сумын төрийн сангийн төлөөлөгч” гэсэн бүтцээр хэрэгжүүлэхээр тус тус тогтоожээ.

ТТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.2-т “Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сан нь тухайн шатны Захирагчийн ажлын албаны дэргэд байна.” гэж заасан байна.

Аудитын хамрах хугацаанд ЗГ-ын 2024 оны 81¹² дүгээр тогтоол /ЗГ-ын 2025 оны 35 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/-оор нийслэлийн ЗДТГ-ын бүтэц, нийслэл, дүүргийн орон тооны хязгаарыг 1 удаа, нийслэлийн ЗД-ын 2023 оны А/152, 2024 оны А/449, 2025 оны А/128, А/870 дугаар захирамжуудаар нийслэлийн ЗДТГ-ын бүтэц, орон тооны хязгаарыг 4 удаа, 2024 оны А/444¹³, 2025 оны А/404¹⁴ дүгээр захирамжуудаар дүүргүүдийн ЗДТГ-ын бүтэц, орон тооны хязгаарыг 2 удаа шинэчилсэн баталсан байна.

Дээрх шийдвэрүүдэд үндэслэн дүүргүүдийн ЗД-ын захирамж, ЗДТГ-ын даргын тушаалаар тухайн шатны ЗДТГ-ын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг 2-3 удаа тус тус шинэчлэн баталжээ. /Дэлгэрэнгүйг хавсралт №1/

Дүрслэл №2. Нийслэл, дүүргүүдийн СТСХ-ийн бүтэц



Дээрх эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрээр тухайн шатны ЗДТГ-ын зохион байгуулалтын бүтцэд төрийн сангийн нэгжийг оруулж, орон тоог баталж байгаа нь ТТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.2-т “...аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн

¹¹ Төрийн сангийн тогтолцоонд шилжих тухай;

¹² Засгийн газрын 2024 оны 02 сарын 28-ны өдрийн “Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны бүтэц, Нийслэл, дүүргийн засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” 81 дүгээр тогтоол

¹³ Нийслэлийн ЗД-ын 2024 оны А/444 дүгээр “Дүүргийн ЗДТГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” захирамж

¹⁴ Нийслэлийн ЗД-ын 2025 оны А/404 дүгээр “Дүүргийн ЗДТГ-ын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” захирамж



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд ... байна.” гэж заасантай нийцэхгүй байна. Тухайлбал:

Аудитын явцад шалгаагдагч байгууллагуудаас үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийн талаар санал авахад Төрийн сангийн нэгж нь чиг үүргийн хүрээнд тухайн шатны ЗДТГ-ын санхүү, төсвийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавихаар ТТХ-д заасан боловч зохион байгуулалтын хувьд ЗДТГ-ын бүтцийн нэгжид хамаарч байгаа нь санхүү, төсвийн дотоод хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх, холбогдох зөвлөмж, чиглэл хүргүүлэхэд хүндрэл үүсгэж байна” гэжээ.

Дүгнэлт: Эрх бүхийн албан тушаалтны шийдвэрээр тухайн шатны засаг даргын тамгын газрын бүтцэд төрийн сангийн нэгжийг харьяалуулан зохион байгуулж байгаа нь төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-д “... дэргэд ...” байх зохицуулалтын агуулгатай бүрэн нийцээгүй байна.

1.2. Төрийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтэц бүрдсэн байна уу?

Төрийн сангийн дунд шатны нэгжүүдийн батлагдсан бүтэц, орон тоо нь хуульд заасан чиг үүргийг бүрэн, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна. Тухайлбал:

Жишиг зааварт тусгасан зарим чиг үүргийг АТТ-д бүрэн тусгаагүй, шаардлагатай орон тоог батлаагүйгээс чиг үүргийн хэрэгжилт хязгаарлагдсан нөхцөл үүсжээ.

Төрийн сангийн цахим системийн удирдлага, зохицуулалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Нийслэлийн ЗД-ын 2025 оны А/1213 дугаар захирамжаар “Нийслэлийн кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам”-ыг баталсан байна.

1.2.1. Төрийн сангийн үйл ажиллагааг явуулж буй бүтэц, зохион байгуулалт оновчтой байна уу?

ТТХ-ийн 36 дугаар зүйлд “Төрийн сангийн тогтолцоо”-г зохицуулж, хуульчилсан байна. Үүнд:

- Төрийн сангийн тогтолцоо нь төв болон орон нутгийн төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогчоос бүрдэнэ,
- Орон нутгийн төрийн сангийн нэгж нь тухайн шатны ЗДТГ-ын дэргэд байна,
- Мөн төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болох бөгөөд ийм алба байгуулсан тохиолдолд давхардсан орон тоо ажиллуулахыг хориглоно,
- Түүнчлэн төрийн сангууд шат шатандаа санхүүгийн дотоод хяналт хэрэгжүүлнэ.

Аудитын хамрах хугацаанд нийслэлийн хэмжээнд 1, дүүргийн хэмжээнд 9 төрийн сангийн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр нь өмнөх асуудалд дурдсанчлан ТТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь заалт, мөн ТСҮАЖ-ын 3.9.8 дахь хэсэг бүрэн хэрэгжээгүйгээс шалтгаалж төрийн сангийн хэвийн үйл ажиллагаа алдагдах, санхүүгийн дотоод хяналтын үр нөлөө буурах, мөн төсвийн хэрэгжилтэд тавих хяналт, хариуцлагын тогтолцоо сулрах зэрэг эрсдэл үүсч болзошгүй нөхцөл байдал үүссэн байна. Тухайлбал:



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”



• ТТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх явцад төрийн сангийн нэгжүүд тухайн шатны ЗДТГ-ын бүтцэд багтаж, бусад нэгжтэй ижил статустай ажиллаж байгаагаас хараат бус байдлаар хяналт хэрэгжүүлэх боломж хязгаарлагдах,

• Мөн нийслэл, дүүргүүдийн хэмжээнд ТСҮАЖ-ын 3.9.8 дахь хэсэгт заасан “Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан албан тушаалтан...” төрийн сангийн 8 нэгжид байхгүйгээс дотоод үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг үнэлэх, хяналт хэрэгжүүлэх, хариу

арга хэмжээ авч зөвлөмж хүргүүлэх зэрэг үйл ажиллагаа доголдох зэрэг нөхцөл байдал үүсжээ.

ТАТХ-ийн 53 дугаар зүйлийн 53.1¹⁵-т “байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллах”-ыг заасан.

ЗГ-ын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын

• 2.1-т “Стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд арга хэмжээний төлөвлөгөө батлагдсанаас хойш хоёр сарын дотор салбарын, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн, байгууллагын стратеги төлөвлөгөөг тус тус дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулна”,

• 2.2-т “Төрийн албаны тухай хуулийн 53.1-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам нь тухайн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулан төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна” гэж заажээ.

Нийслэлийн ЗД-ын 2021 оны А/667 дугаар захирамжаар “Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-г, А/880 дугаар захирамжаар “НЗДТГ-ын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-г, 2025 оны А/1615 дугаар захирамжаар “НЗДТГ-ын 2024-2028 оны оны стратеги төлөвлөгөө”-г тус тус баталж, төрийн сангийн нэгжийн чиг үүргийг дараах байдлаар тусгасан байна.

¹⁵ 53.1. Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

Дүрслэл №3. Нийслэл болон нийслэлийн ЗДТГ-ын стратеги төлөвлөгөө

Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө

- Стратеги зорилт-3 "Эдийн засгийн зорилтод түвшинг бүрэн хангана"
- 4.1 . Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн зорилтот түвшинг бүрэн хангана

Нийслэлийн ЗДТГ-ын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө

- Стратеги зорилт-3 Санхүүгийн нөөцөөс хамаарч бодлого, шийдвэрийн хяналт- шинжилгээ тасалдаггүй болсон байна.

Нийслэлийн ЗДТГ-ын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө

- Стратеги зорилт-4 Хариуцлагатай, ил тод үр ашигтай, төсвийн удирдлагыг нэвтрүүлнэ.

ТАТХ-ийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх заалт, ЗГ-ын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын 2.2 дах хэсэгт заасны дагуу СБД, СХД-ийн ЗДТГ 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг, БХД, ХУД-ийн ЗДТГ 2023-2024 оны (1 жилийн) стратеги төлөвлөгөөг тус тус батлуулсан бол бусад дүүргүүд стратеги төлөвлөгөөгөө батлуулаагүй, харин 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг дүүргүүдийн ЗДТГ одоог хүртэл батлуулаагүй нь холбогдох хууль, журамд заасныг хэрэгжүүлээгүй байна.

Дүгнэлт: Төрийн сангийн дунд шатны нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт нь холбогдох хуульд заасан чиг үүргийг бүрэн, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд нөлөөлж байна.

1.2.2. Төрийн сангийн албан хаагчдын гүйцэтгэж буй чиг үүрэг давхардалгүй, ажлын байрны тодорхойлолттой нийцэж байна уу?

ТТХ-аар төрийн сангийн чиг үүргийг зааж, СС-ын 2015 оны 90 дүгээр тушаалаар “Орон нутгийн санхүү төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ыг баталжээ.

Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжийн албан хаагчдын АТТ-д заасан чиг үүргийн тоог харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

Дүрслэл №4. АТТ-д заасан чиг үүргийн харьцуулалт /бага, дундаж, их/





СС-ын баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар” нь ТТХ-д заасан Төрийн сангийн чиг үүрэгтэй уялдсан бөгөөд аудитаар АТТ-д бүрэн туссан эсэхийг тулгахад:

Нийслэл ЗДТГ-ын СХОГ-ын СТСХ:

- Зааврын 3 дах хэсэг “Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтсийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын 3.1 дэх хэсэг “Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга”, 3.1.3-т “Дүүргийн төсвийн ерөнхий нягтлан бодогчдыг томилох, чөлөөлөхөд санал боловсруулан Засаг даргад танилцуулан шийдвэрлүүлэх” гэж заасан байхад нэгжийн даргын АТТ-д тусгаагүй,
- 3.2 дах хэсэг “Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч”, 3.2.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл боловсруулахад санал өгөх” гэж заасан байхад Ерөнхий нягтлан бодогчийн АТТ-д тусгаагүй,
- 3.4 дэх хэсэг “Бүртгэлийн мэргэжилтэн”, 3.4.9-т “Торгууль, шийтгэврийн хуудасны тайланг цаг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх” гэж заасан байхад Бүртгэлийн мэргэжилтний АТТ-д тусгаагүй,
- 3.6 дах хэсэг “Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн”, 3.6.3-т “Хяналтын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг удирдлагаар батлуулж, хэрэгжилтийг хангуулах, биелэлтийн нэгдсэн дүн, тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлэх” гэж заасан байхад Дотоод хяналт хариуцсан мэргэжилтний АТТ-д тусгаагүй байна.

Дүүргүүдийн СТСХ:

- Зааврын 4 дах хэсэг “Дүүргийн санхүү, төрийн сангийн хэлтсийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын 4.1 дэх хэсэг “Хэлтсийн дарга”, 4.1.13-т “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журмын дагуу холбогдох төсвийн шууд захирагчийн ерөнхий, ахлах нягтлан бодогчийг томилох, чөлөөлөхөд төсвийн эрх захирагчтай санал зөвшилцөх” гэж заасан байхад нэгжийн даргын АТТ-д тусгаагүй,
- 4.2 дах хэсэг “Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч”, 4.2.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл боловсруулахад санал өгөх” гэж заасан байхад Ерөнхий нягтлан бодогчийн АТТ-д тусгаагүй,
- 4.3 дэх хэсэг “Бүртгэлийн мэргэжилтэн”, 4.3.9-т “Торгууль, шийтгэврийн хуудасны тайланг цаг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх” гэж заасан байхад Бүртгэлийн мэргэжилтний АТТ-д тусгаагүй,
- 4.4 дах хэсэг “Төсвийн мэргэжилтнүүд (орлого, зарлага, салбарын)”, 4.4.12-т “Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хэрэгжилтийн талаар иргэд, төр олон нийтийн байгууллагад мэдээлэл өгөх” гэж заасан байхад Төсвийн мэргэжилтний АТТ-д тусгаагүй,
- 4.5 дах хэсэг “Гүйлгээ баталгаажуулах ажил хариуцсан мэргэжилтэн”, 4.5.9 “Дүүргийн ЗГСУМС-ийн хэрэглэгчийн болон тэмдгийн бүртгэлийг хөтөлж, холбогдох байгууллагад хүргүүлнэ” гэж заасан байхад БНД, НД-үүдээс бусад дүүргийн Банкны төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний АТТ-д тусгаагүй байна.

Мөн нийтлэг байдлаар тухайн нэгжийн аль нэг албан тушаалтан “ээлжийн амралт, чөлөөтэй байх хугацаанд орлох” чиг үүргийг АТТ-д огт тусгаагүй байна.

Аудитаар ТАТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.6¹⁶-д “Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг ... албан тушаал тус бүрээр батална” гэж заасан бөгөөд батлагдсан АТТ-д заасан “Албан тушаалд тавигдах тусгай шаардлага” хэсгийн

¹⁶ 23.6. Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.5-д заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална.



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

боловсрол, мэргэжил, мэргэшлийн шаардлагыг хангасан эсэхийг тулгахад боловсрол, мэргэжлийн шаардлагыг бүрэн, мэргэшлийн шаардлагыг 55.2 хувь нь хангасан байна.

Хүснэгт №4. Албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангасан байдал

№	Тусгай шаардлагын нэршил	Нийт албан хаагчдын тоо	Тусгай шаардлагыг		
			Хангах албан хаагчдын тоо	Хангасан албан хаагчдын тоо	Хангаагүй албан хаагчдын тоо
1	Боловсрол	104	104	104	-
2	Мэргэжил		104	104	-
3	Мэргэшил /Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх/		1	1	-
4	Мэргэшил /Төрийн албаны богино, дунд хугацааны сургалтад хамрагдсан байх/		95	52	43

Эх сурвалж: Аудитын баг

Төрийн сангийн нэгжийн албан хаагчид хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхэлсэн эсэхэд горим, сорил хэрэгжүүлэхэд ТАТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1.17¹⁷ дахь заалтыг баримтлан ажилласан байна. Харин батлагдсан орон тооноос дутуу ажиллаж байгаа шалтгаанаар зарим дүүргийн төрийн сангийн албан хаагчид эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр сул орон тооны чиг үүргийг хавсран гүйцэтгэж байна. Үүнд:

Хүснэгт №5. Томилогдсон албан тушаалаас бусад чиг үүргийг хавсран гүйцэтгэж байгаа албан хаагчдын мэдээлэл

№	Дүүрэг	Төрийн сангийн нэгжийн орон тоо			Бусад чиг үүргийг хавсран гүйцэтгэж байгаа албан хаагч
		Батлагдсан	Ажиллаж байгаа	Сул	
1	БХД	6	5	1	“Ерөнхий нягтлан бодогч” нь “Банкны төлбөр, тооцоо хариуцсан мэргэжилтэн”-ий чиг үүргийг хавсран гүйцэтгэж байна.
2	БГД	12	11	1	“Сургалт, орон нутгийн өмч хариуцсан мэргэжилтэн” нь “Бүртгэлийн мэргэжилтэн”-ий чиг үүргийг хавсран гүйцэтгэж байна.
3	НД	7	6	1	“Бүртгэл, орлого, сургалт хариуцсан мэргэжилтэн” нь “Өмч хариуцсан мэргэжилтэн”-ий чиг үүргийг хавсран гүйцэтгэж байна.
4	СБД	12	9	3	1. “Орлого, эдийн засгийн асуудал хариуцсан мэргэжилтэн” нь “Төсвийн мэргэжилтэн”-ий чиг үүргийг, 2. “Сургалт, тайлан мэдээ хариуцсан 2 мэргэжилтэн” нь “Банкны төлбөр, тооцоо хариуцсан 2

¹⁷ 37.1.17.үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх;




“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

					мэргэжилтэн”-ий чиг үүргийг хавсран гүйцэтгэж байна.
5	ХУД	12	11	1	“Төлбөр тооцоо хариуцсан ахлах мэргэжилтэн” нь “Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн”-ий албан үүргийг хавсран гүйцэтгэж байна.

Эх сурвалж: Аудитын багт ирүүлсэн судалгаа

Төрийн сангийн нэгжийн ажлын ачааллыг 2023-2025 онд гүйцэтгэсэн гүйлгээний тоогоор авч үзэхэд БХД, НД, БНД нь 19-47 байгууллагын 101-169 дансаар 5720-21763 удаагийн, БГД, СБД, ХУД нь 79-90 байгууллагын 203-310 дансаар 28691–34070 удаагийн, СХД, ЧД, БЗД болон нийслэлийн төрийн сангийн нэгж нь 72-134 байгууллагын 179-292 дансаар 45686–57737 удаагийн гүйлгээг тус тус хийсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №2/



Үүнээс үзэхэд нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжүүдийн 30 хувь нь дундаж, 40 хувь нь ажлын өндөр ачаалалтай ажиллаж байгаа нь харагдаж байна.

Дүгнэлт: Төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод зарим чиг үүргийг бүрэн тусгаагүй байна.

1.2.3. Төрийн сангийн цахим системийн удирдлага, зохицуулалт, мэдээллийн аюулгүй байдал нь холбогдох хууль тогтоомж, стандартад нийцэж, хэрэгцээ шаардлагыг нь бүрэн хангаж байна уу?

ТТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Бүх шатны төсөв боловсруулах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналтыг төсвийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ”, 37 дугаар зүйлийн 37.1.5-д “төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих” гэж тус тус заасан байна.

Дээрх хуулийн 38 дугаар зүйлд заасан “Төв төрийн сангийн чиг үүрэг”-ийн дагуу СЯ-ны ТСГ-нь ТТХ-ийн хэрэгжилтэд хяналт тавих, нийслэл, дүүргийн нийгэм, эдийн засгийн зорилтыг ханган биелүүлэхэд төсөв, санхүүгийн зохистой харьцааг бүрдүүлж, төрийн сангийн үйлчилгээг байгууллага, иргэдэд оновчтой хүргэн, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлж, нягтлан бодох бүртгэл, өмчийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулах, бүртгэл, тооцооны ажилтнуудын чадавхыг дээшлүүлж, хэрэглэгчдийг бодит мэдээллээр хангах үйл ажиллагааны хүрээнд дараах цахим системүүдийг хэрэглэж байна. Тухайлбал:



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

Дүрслэл №5. Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой зарим системүүд



Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем /Government/



Төрийн сангийн удирдлагын цахим систем /ТСУЦС/



Төрийн албаны цалингийн нэгдсэн систем



Банк хоорондын төлбөр тооцоо /ACH+/



Гадаад валютын систем

ТТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.1.4¹⁸-д заасныг үндэслэн СС-ын 2024 оны 256 дугаар тушаалаар “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх заавар”-ыг баталсан байна.

МУЗЗНДНТУТХ-ийн 63 дугаар зүйлийн 63.1.1¹⁹, 66 дугаар зүйлийн 66.1²⁰, МУНУБХЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5²¹, КАБТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.2²² дахь заалтад үндэслэн нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цахим мэдээллийн сан, мэдээллийн систем, түүнийг дэмжих дэд бүтцийн кибер аюулгүй байдлыг хангах зорилгоор Нийслэлийн ЗД-ын 2025 оны А/1213 дугаар захирамжаар “Нийслэлийн кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам”-ыг баталж нийслэл, дүүргийн хэмжээнд мөрдүүлэн ажиллаж байгаа нь сайн жишиг болсон байна.

Аудитын явцад төрийн сангийн үйл ажиллагаанд хамаарах нийслэл, дүүргийн хэмжээний 517 албан хаагчдаас “Төрийн сангийн цахим системийн ашиглалт, хүртээмж, найдвартай байдал нь төрийн сангийн ажилтны ажлын хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаа эсэх” талаар судалгаа авахад дараах байдлаар хариулсан байна. Үүнд:

¹⁸ 38.1.4.төрийн сангийн үйл ажиллагааны журам, зааврыг боловсруулж хэрэгжүүлэх;

¹⁹63.1.1.хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцан зохион байгуулах;

²⁰66.1.Засаг дарга энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана;

²¹22.5.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргана;

²²7.2.Энэ хуулийн 16.1, 17.1, 19.1-д заасан хуулийн этгээд нь Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журамд нийцсэн кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журамтай байна.



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

Дүрслэл №6. Төрийн сангийн цахим системийн талаар авсан судалгааны нэгтгэл

Төрийн сангийн цахим систем нь албан хаагчийн ажлын хэрэгцээг хэр хангаж байгаа талаар	→	58.5 хувь буюу 302 албан хаагч “Бүрэн хангаж байгаа”,
	→	41.5 хувь буюу 215 албан хаагч “Хэвийн”.
Төрийн сангийн цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг эсэхэд	→	67.6 хувь буюу 349 албан хаагч “Интернэт саатал, программ тасалдал”,
	→	21.4 хувь буюу 111 албан хаагч “Хүндрэл гардаггүй хэвийн”,
	→	5.6 хувь буюу 29 албан хаагч “Сургалт хангалтгүй”,
	→	5.4 хувь буюу 28 албан хаагч “Бусад”.
Төрийн сангийн цахим систем ашиглахад ойлгомжтой, хялбар байгаа эсэх	→	96.7 хувь буюу 500 албан хаагч “Тийм”,
	→	3.3 хувь буюу 17 албан хаагч “Үгүй”.
Төрийн сангийн цахим системийн аюулгүй байдал хангагдсан гэж үзэж байгаа эсэх	→	67.1 хувь буюу 347 албан хаагч “Тийм”,
	→	31.3 хувь буюу 162 албан хаагч “Мэдэхгүй”,
	→	1.6 хувь буюу 8 албан хаагч “Үгүй”.
Системүүд хоорондоо мэдээллээ үнэн зөв, шууд солилцож, уялдаа холбоотой ажиллаж чадаж байгаа эсэх	→	84.1 хувь буюу 435 албан хаагч “Тийм”,
	→	15.9 хувь буюу 82 албан хаагч “Үгүй”.
Системд үүссэн асуудлыг систем хариуцагч байгууллагын зүгээс бүрэн, шуурхай шийдвэрлэдэг эсэх	→	71.1 хувь буюу 368 албан хаагч “Тийм”,
	→	25.3 хувь буюу 131 албан хаагч “Удаашралтай”,
	→	3.6 хувь буюу 18 албан хаагч “Үгүй, шуурхай шийдвэрлэдэггүй” гэж тус тус хариулжээ.

Дүгнэлт: “Нийслэлийн кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам”-ыг боловсруулан баталж, мөрдүүлсэн нь сайн жишиг болжээ. Харин судалгааны үр дүнгээс харахад интернэт, программын саатал, техникийн дэмжлэг, сургалтын хүртээмжийг сайжруулахад анхаарах шаардлагатай байна.



БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ХЭРЭГЖИЖ БАЙНА УУ?

Төсвийн байгууллага урсгал болон хөрөнгийн зардлын төлбөрийн санхүүжилт, зарцуулалтын эрх олголтыг нээх, төрийн сангийн дансны төлбөр тооцоог гүйцэтгэхдээ холбогдох хууль, журамд нийцүүлсэн байна.

Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой болон эдийн засгийн ангилал зөрүүлж санхүүжилт олгосон зөрчлүүд жил бүр давтагдан гарсаар байна.

2.1 Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт батлагдсан төсөв, төсвийн хуваарь хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байна уу?

Төсвийн санхүүжилт болон зарцуулалтын эрхийг холбогдох хууль, журамд нийцүүлэн тухайн шатны төрийн сангийн нэгжээс боловсруулж, нийслэл, дүүргийн ЗД-аар орон нутгийн төсвийн хуваарийг батлуулж, төв төрийн сангаас зарцуулалтын эрхийг нээлгэж, батлагдсан төсвийн хуваарьт нийцүүлэн олгосон байна.

Зарим гүйлгээний эрхийг олгохдоо холбогдох хууль, журамд заасныг баримтлаагүй байна.

2.1.1. Төсвийн санхүүжилтийн эрх олголт нь батлагдсан төсвийн хуваарь хууль тогтоомж, холбогдох баримт бичгийн шаардлагад нийцэж, хугацаанд нь олгогдож байна уу?

ТТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1.8²³-д “төрийн сан нь төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох” чиг үүргийг тусгажээ.

Төсвийн санхүүжилтийн эрх олгох асуудлыг 2013-2023 онд СС-ын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн олгох журам”²⁴-аар, 2023 оноос хойш ЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан ТСҮАЖ-аар зохицуулж байна.

Аудитын хамрах хугацаанд нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгж нь ТТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1.8, ТСҮАЖ-ийн 2 дугаар хэсгийн 2.1²⁵-д заасны дагуу нийслэл, дүүргүүдийн 2023-2025 оны батлагдсан төсвийн хуваарийг дараах байдлаар баталжээ.

Хүснэгт №6. Нийслэл, дүүргүүдийн батлагдсан төсөв

№	Нэр	Батлагдсан төсвийн мөнгөн дүн		
		2023 он	2024 он	2025 он
1	БНД	22,142.26	37,654.20	42,351.10
2	БХД	7,205.00	10,748.00	15,514.34
3	БЗД	294,550.44	386,387.25	381,001.81
4	БГД	188,155.62	280,088.51	355,087.80
5	НД	20,161.77	30,890.71	39,791.96
6	СБД	419,305.11	635,567.80	722,705.10
7	СХД	109,201.22	180,494.80	210,831.24
8	ХУД	354,276.20	529,688.40	608,293.50

/сая.төг/

²³ 37.1.8.төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох.

²⁴ СС-ын 2025 оны 162 дугаар “Тушаал хүчингүй болсонд тооцох тухай” тушаалаар хүчингүй болсонд тооцсон.

²⁵ 2.1 Төрийн сан төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг Төсвийн тухай хуулийн 37.1.8-д заасны дагуу төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн олгоно



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”


9	ЧД	195,204.00	262,712.37	326,679.62
10	Нийслэл	1,648,182.10	3,405,515.34	4,567,511.60
	Нийт	3,258,383.71	5,759,747.27	7,269,768.16

Эх сурвалж: Нийслэл, дүүргийн ИТХ-ын 2023-2025 оны тогтоолууд, батлагдсан төсөв

Хүснэгтээс харахад нийслэл, дүүргүүдийн батлагдсан төсөв 2023-2025 онд жил дараалан өссөн байна. Нийт төсөв 2023 онд 3,258,383.71 сая төгрөг байсан бол 2025 оны мөн үеэс 7,269,768.16 сая төгрөг болж 2.2 дахин өссөн байна.

Тайлант хугацаанд нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжид нийт 10,933 удаагийн 11,681.92 сая төгрөгийн санхүүжилтийн эрх олгох хүсэлт ирүүлснээс 99.7 хувийг шийдвэрлэсэн байна.

График №1. Санхүүжилтийн эрх олгох хүсэлт болон гүйцэтгэлийн мэдээлэл



Эх сурвалж: Нийслэл болон дүүргүүдийн төрийн сангийн нэгжүүдээс ирүүлсэн мэдээлэл

Дээрх мэдээллээс харахад тайлант хугацаанд олгосон санхүүжилтийн эрх нь батлагдсан төсөвт багтсан байна.

Аудитаар нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжээс төсвийн санхүүжилтийн эрх олгохдоо хууль, журамд заасан шаардлагыг үндэслэсэн эсэхийг түүвэрлэн тулган баталгаажуулахад 69,312.62 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- БХД-ийн төрийн сангийн нэгж 2023-2025 онд санхүүжилтийн эрх нээх хүсэлтийг батлагдсан маягтын дагуу ирүүлээгүй байхад 6 байгууллагад 14.95 сая төгрөгийн санхүүжилтийн эрх олгосон, /Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв./
- Санхүүжилтийн эрх нээх хүсэлтэд эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, баталгаажуулаагүй буюу анхан шатны баримт хүчин төгөлдөр бус байхад:
- Нийслэлийн ЗДТГ-ын төрийн сангийн нэгж 2023 онд давхардсан тоогоор 239 байгууллагад 68,552.43 сая төгрөг, /Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв./
- БЗД-ийн төрийн сангийн нэгж 2023 онд 8 байгууллагад 404.26 сая төгрөг, /Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв./
- БГД-ийн төрийн сангийн нэгж 2024, 2025 онд 5 байгууллагад 340.98 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг тус тус олгосон байна. /Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв./
- Мөн Төрийн сангийн нэгжүүдэд дараах 2 зөрчил нийтлэг байдлаар илэрч байна:
 - ТСҮАЖ-д заасан “... хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийн эрхийн хүсэлт” маягт-СЭБ-3, “Улс (орон нутгийн) төсвийн байгууллагуудад санхүүжилтийн эрх олгох жагсаалт” маягт ЗЭБ№1-ийн бүтэц, загварт өөрчлөлт оруулсан /цаасаар/,
 - Улс (орон нутгийн) төсвийн байгууллагуудад санхүүжилтийн эрх олгох жагсаалт” маягт ЗЭБ№1-ийг төрийн сангийн үйл ажиллагааны цахим системд нэвтрүүлээгүйгээс



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

тус хүсэлтийг цахимаар хүргүүлэхдээ “Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд залруулга хийлгэх хүсэлт” Маягт-ЗХХ-1-ийг ашиглаж байна.

Дээрх зөрчлүүд нь НББТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.5²⁶ дахь заалт, СС-ын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн олгох журам”-ын 4.3²⁷, ЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан ТСҮАЖ-ын 2.6²⁸ дахь хэсэгт заасантай тус тус нийцээгүй байна.

Дүгнэлт: Санхүүжилтийн эрх олголтыг батлагдсан төсвийн хуваарьт нийцүүлэн олгож байгаа ч зарим гүйлгээний эрхийг олгохдоо холбогдох хууль, журмыг бүрэн баримтлаагүй байна.

2.1.2 Төсвийн зарцуулалтын эрх олголт нь батлагдсан төсөв зориулалт, эдийн засгийн ангилал болон шаардлагад нийцэж хэрэгжиж байна уу?

ТТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.43²⁹, 37 дугаар зүйлийн 37.1.8³⁰ дахь заалт, ТСҮАЖ-ын 2.7.1³¹ дэх хэсэгт заасны дагуу зарцуулалтын эрхийг тухайн шатны төрийн сангийн нэгжээс ирүүлсэн батлагдсан төсвийн хуваарийн дагуу Төв төрийн сангаас нээж байна.

Тайлант хугацаанд Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжээс 16,287,899.14 сая төгрөгийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу зарцуулалтын эрх нээлгүүлэхээр төв төрийн санд хүсэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт №7. Батлагдсан төсвийн гүйцэтгэл, зөрүү

/сая.төг/

№	Нэр	2023-2025 оны нэгтгэл			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	БНД	102,147.55	84,037.86	18,109.69	82.3
2	БХД	33,467.27	30,548.99	2,918.28	91.3
3	БЗД	1,061,939.50	865,277.81	196,661.70	81.5
4	БГД	823,331.95	754,648.34	68,683.60	91.7
5	НД	90,844.44	81,215.95	9,628.49	89.4
6	СБД	1,777,577.96	1,563,797.35	213,780.61	88.0
7	СХД	500,527.24	420,747.57	79,779.67	84.1
8	ХУД	1,492,258.19	1,323,604.43	168,653.76	88.7
9	ЧД	784,595.98	681,341.63	103,254.35	86.8
10	Нийслэл	9,621,209.05	7,425,340.84	2,195,868.20	77.2
НИЙТ		16,287,899.14	13,230,560.79	3,057,338.34	81.2

Эх сурвалж: НТАГ-ын САА-ны 2023-2025 оны нэгтгэсэн тайлан

²⁶ 13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.

²⁷ 4.3. Аймаг, нийслэлийн төрийн сан нь Засаг даргын баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжилтийн эрхийн тооцоог хийж, орон нутгийн төсвийн байгууллагын санхүүжилтийг сар бүрийн ажлын эхний 5 өдөрт багтаан ЗЭБ№1 маягтаар, тусгай зориулалтын шилжүүлгийг санхүүжилт орсноос хойш ажлын 2 өдөрт багтаан ЗЭБ№1 маягтаар тус тус баталгаажуулан аймаг, нийслэлийн төсвийн ерөнхий нягтлан бодогч олгоно.

²⁸ 2.6. Орон нутгийн төсвийн санхүүжилтийн эрх олгох журам:

²⁹ 4.1.43. "зарцуулалтын эрх" гэж батлагдсан төсвийн хүрээнд төсвийн байгууллагын сар, улиралд зарцуулах төсвийн дээд хязгаарыг;

³⁰ 37.1.8. төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох.

³¹ 2.7.1. Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан улсын төсвийн болон Засаг даргын баталсан орон нутгийн төсвийн хуваарийн дагуу зарцуулалтын эрхийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор олгоно;



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

Хүснэгтээс харахад ТСҮАЖ-ын 2.7.1³² дэх хэсэгт заасны дагуу тухайн жилийн батлагдсан төсвийн хуваарийг сар, улирал, жилээр боловсруулан батлуулж төв төрийн санд хүргүүлсний дагуу эрхийг нээж санхүүжилтийг олгосон байна.

Тайлант хугацаанд нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжээс 16,287,899.14 сая төгрөгийн батлагдсан төсвийн хуваарийг хүргүүлснээс төв төрийн сангаас хянан зарцуулалтын эрхийг нээж 13,230,560.79 сая төгрөг буюу 81.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

ТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1³³, 70 дугаар зүйлийн 70.3³⁴ дэх хэсэгт “...тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана, ... төсвийн тухай хуульд заасан зардлыг хэтрүүлсэн, ангилал зөрүүлсэн ...” хариуцлага хүлээлгэхээр заажээ. НТАГ-ын САА-аас 2023-2025 онд НЗД-ын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 712.66 сая төгрөгийн дүнтэй, “эдийн засгийн ангилал зөрүүлж шилжүүлсэн” 36 зөрчлийг илрүүлж, аудитын шийдвэр хүргүүлж ажилласан байна. Тухайлбал: /Дэлгэрэнгүйг хавсралт №3/

- БЗД-ийн Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын хэлтэс- 32.3 сая /2023 он/
- СХД-ийн ЗДТГ-100.7 сая төгрөг /2024 он/
- СБД-ийн ЗДТГ-234.7 сая төгрөг /2025 он/

Дүгнэлт: Тухайн шатны төрийн сангийн нэгжээс батлагдсан төсвийн хуваарийг хүргүүлсний дагуу төв төрийн сангаас зарцуулалтын эрхийг нээж байна.

2.2. Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагаа хууль, журмын дагуу баталгаажин, нэгдсэн хяналттайгаар хэрэгжиж байна уу?

Төрийн сангийн нэгж нь төлбөр тооцоог гүйцэтгэхдээ холбогдох эрх зүйн актыг баримтлан санхүүгийн системд бүртгэх, дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах, залруулгын гүйлгээг хийж, шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцааж байна.

Гэвч санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой болон тайлан, мэдээг тогтоосон хугацаанаас хоцорч хүргүүлэх, хүргүүлээгүй зөрчлүүд давтагдан гарсаар байна.


³² 2.7.1. Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан улсын төсвийн болон Засаг даргын баталсан орон нутгийн төсвийн хуваарийн дагуу зарцуулалтын эрхийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор олгоно;

³³ 22.1 Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана.

³⁴ 70.3 Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн төсвийн тухай хуульд заасан зардлыг хэтрүүлсэн, ангилал зөрүүлсэн, зориулалт бусаар ашигласан бол тухайн эрхэлж байгаа албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно.



Дүрслэл №7. Төрийн сангийн төлбөр тооцооны өнөөгийн байдал



Эх сурвалж: Сангийн яам

2.2.1. Төв төрийн сан нэгдсэн данс, бүртгэлийн дансны төлбөр тооцоо, гадаад валют, үлдэгдэл, баталгааг хугацаандаа холбогдох системд бүртгэх, Монгол банк дахь төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэлтэй тулган баталгаажуулж, зөрүүг тухай бүр залруулах арга хэмжээ авч байна уу?

ТТХ-ийн 35³⁵ дугаар зүйлд төсвийн байгууллагын орлого, зарлагын гүйлгээг төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд зөвхөн холбогдох байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээж, ашиглахыг харилцааг зохицуулсан байна.

Төрийн сангийн нэгж нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Орон нутгийн орлого”-ын 1003, “Бүртгэл”-ийн 1161, “Гадаад валют”-ын 3, нийт 2167 данстай байна.

Мөн арилжааны банкинд засгийн газрын санхүүжилтийн 1, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 583, төсвийн байгууллагын 12, нийт 596 данс байна.

Нийслэл, дүүргийн төрийн сан 2023-2025 онд нийт 750-785 байгууллагын 2,158-2,228 дансаар 1,025,736 удаагийн гүйлгээг холбогдох системүүдээр гүйцэтгэсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №4/

Хүснэгт №8. Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжийн 2023-2025 оны үйл ажиллагааны үзүүлэлтүүд

№	Огноо	Байгууллагын тоо	Дансны тоо	Гүйлгээний тоо
1	2023	750	2,228	279,381

³⁵ 35 дугаар зүйл. Төрийн сангийн нэгдсэн данс



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

2	2024	761	2,158	376,457
3	2025	785	2,167	369,898
Нийт				1,025,736

Эх сурвалж: Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжээс ирүүлсэн мэдээлэл

Мөн төрийн сангийн данс болон бусад мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2023 онд 1,017,906.07 сая төгрөг, 2024 онд 3,249,337.43 сая төгрөг, 2025 онд 2,604,681.94 сая төгрөг байсан бөгөөд ТСҮАЖ-д заасны дагуу тогтоосон хугацаанд дээд шатны төрийн сангийн нэгжүүдтэй тулгалт хийж, баталгаажуулсан байна.

ТТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.6³⁶ дахь заалт, ТСҮАЖ-ын 3.7³⁷ дахь хэсэгт гадаад валютын төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх зорилгоор банкинд данс нээх, түүнийг хаах болон бүртгэлийг холбогдох системд бүртгэх асуудлыг зохицуулжээ.

Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгч нарын 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалаар “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банкинд нээх, хаах, тайлагнах журам”-ыг баталсан байна.

Монгол Улсын хэмжээнд төсвийн байгууллагын гадаад валютын төлбөр, тооцоог multicurrency.finance.gov.mn системээр гүйцэтгэж байгаа бөгөөд нийслэлийн төрийн сангийн нэгжид гадаад валютын 3, үүнтэй холбоотой СЯ болон арилжааны банканд 6 данстай байна. Үүнд:

Хүснэгт №9. Нийслэлийн гадаад валютын данс болон уг данстай холбоотой ашиглагддаг бусад дансны мэдээлэл

№	Зориулалт	Гадаад валют	Данс
Төрийн банк			
1	Свип үйлчилгээний данс	Доллар	106000079910
2		Евро	106000079929
3		Иен	106000079932
Сангийн яам			
4	Зузаатгалын данс	Доллар	201200051001
5		Евро	202200051001
6		Иен	203200051001
Нийслэлийн ЗДТГ-ын СХОГ-ын СТСХ			
7	Орлого төвлөрүүлж, хөрвүүлэх	Доллар	100200051701
8		Евро	100200051702
9		Иен	100200051703

Эх сурвалж: Нийслэлийн ЗДТГ-ын СХОГ-ын СТСХ

Дээрх дансдаар гүйлгээ хийхдээ тухайн байгууллагын албан бичиг, тушаал, шийдвэр болон ТСҮАЖ-ын 3.7.4³⁸-т заасан маягт ТТ-ЗА “Гадаад гуйвуулгын төлбөрийн хүсэлт”-ийг үндэслэн тогтоосон хугацаанд multicurrency.finance.gov.mn системд бүртгэж, 102.30 сая доллар, 5.21 сая евро, 0.80 сая иенийн гүйлгээг тус тус хийжээ.

³⁶ 35.6.Төсвийн байгууллага төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур банканд данс нээх, түүнийг хаахтай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол банктай хамтран батална.

³⁷ 3.7.Гадаад валютын төлбөр тооцоо

³⁸ 3.7.4.Төсвийн байгууллага нь валютаар төлбөр гүйцэтгэхдээ холбогдох системд төлбөрийн мэдээллийг бүртгэж, гадаад гуйвуулгын төлбөрийн хүсэлтийг энэ журмын 3 дугаар хэсэрт заасан "маягт ТТ-ЗА"-ийн дагуу 2 хувь үйлдэн үндэслэх баримтын хамт харьяа төрийн санд цахимаар,эсхүл цаасан хэлбэрээр хүргүүлнэ. Шимтгэл болон хураамжийг төлбөр шилжүүлэгч тал хариуцна;



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

Хүснэгт №10. Нийслэлийн гадаад валютын гүйлгээ

№	Огноо	Байгууллагын тоо	Гүйлгээний тоо	Гүйлгээний дүн
Доллар				
1	2023	3	7	32,030.08
2	2024	2	6	86,573.84
3	2025	5	42	102,182,653.74
Нийт		10	55	102,301,257.66
Евро				
1	2023	1	1	519,319.40
2	2024	1	3	348,679.36
3	2025	3	17	4,345,370.50
Нийт		5	21	5,213,369.26
Иен				
1	2023	1	1	805,490.00
2	2024	-	-	-
3	2025	-	-	-
Нийт		1	1	805,490.00

Эх сурвалж: Нийслэлийн ЗДТГ-ын СХОГ-ын СТСХ

Байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт буюу валютын төлбөрийн хэрэгцээнд үндэслэн гүйлгээг хийсний дараа тухайн дансны үлдэгдлийг 0 болгон хаадаг тул зөрүү болон залруулга хийгддэггүй байна.

Дүгнэлт: Төрийн сангийн данс, төлбөр тооцоог холбогдох системд бүртгэн гүйлгээг хийж, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгаажуулсан байна.

2.2.2. Төрийн сан, төсвийн байгууллага бүртгэлийн дансны төлбөр тооцоо, төлбөрийн хүсэлт, зарлагын гүйлгээг хийхдээ эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдэг, үндэслэх баримт бичиг, мэдээллийг үнэн зөв бүрдүүлж, зориулалт, ангиллын дагуу гүйцэтгэсэн үү?

Төсвийн байгууллага урсгал болон хөрөнгийн зардлын төлбөрийг төрийн сангаар дамжуулан гүйцэтгэхдээ НББТХ болон СС-ын 2016 оны №431 дугаар тушаалаар баталсан “Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг, хавсралт заавар”-г заасан санхүүгийн анхан шатны баримтын иж бүрдлийг ханган ажиллахаар байна.

Төлбөр, тооцоог 2023 оны хоёрдугаар улирлаас өмнө цаасан суурьтайгаар бэлтгэж, гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулан нягтлан бодогч төрийн санд биечлэн хүргэж гүйлгээ хийдэг байсан бол мөн үеэс хойш цахим системд үе шаттайгаар шилжүүлсэн байна.

Аудитаар НББТХ болон СС-ын баталсан зааврын дагуу санхүүгийн анхан шатны баримтын иж бүрдлийг хангасан эсэхийг тулган шалгахад 22,647.54 сая төгрөгийн 715 зөрчил илэрсэн байна. Үүнд:

Цаасан суурьтай баримт /2023 оны I улирал/

- СБД-ийн төрийн сангийн нэгж 44 удаагийн 53.50 сая төгрөг; /Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв./
- ЧД-ийн төрийн сангийн нэгж 2 удаагийн 1.79 сая төгрөг;



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

- ХУД-ийн төрийн сангийн нэгж 5 удаагийн 1.08 сая төгрөгийн төлбөр тооцоог санхүүгийн анхан шатны баримтын иж бүрдэл дутуу байхад баталгаажуулж, гүйлгээ хийсэн.

Цахим систем

НТАГ-ын САА-аас 2023-2025 онд гүйцэтгэсэн аудитаар санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 22,591.17 сая төгрөгийн 664 зөрчлийг илрүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №5/

Энэ нь НББТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.7³⁹ дахь заалт, ТСҮАЖ-ын 3.4.10⁴⁰ дахь хэсэгт заасантай нийцээгүй байна.

Дүгнэлт: Төрийн сангийн үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэн боловч санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэсэн зөрчил давтагдан гарсаар байна.

2.2.3. Төв төрийн сан, бүртгэлийн дансны тодорхойгүй орлого, буцаалтыг журмын дагуу дансанд байршуулж, холбогдох баримтыг үндэслэн гүйлгээг залруулан буцааж байна уу?

ТСҮАЖ-ын 3.4.10-т “Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана”, 4.4.3-т “Төв төрийн сан, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж нь холбогдох баримтыг үндэслэн төрийн сангийн холбогдох бүртгэлийн дансанд дараах залруулгын бичилтийг хийнэ” гэж заасан байна.

Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгж 2023-2025 онд нийт 2,194 байгууллагын 942,922.97 сая төгрөгийн 73,754 гүйлгээг дээрх журамд нийцүүлэн буцаасан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №6/

Хүснэгт №11. Буцаасан гүйлгээний мэдээлэл

№	Огноо	Байгууллагын тоо	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн (сая.төг)
1	2023	719	24640	170,283.07
2	2024	730	23079	346,410.11
3	2025	745	26035	426,229.78
НИЙТ		2194	73754	942,922.97

Эх сурвалж: Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжээс ирүүлсэн судалгаа


³⁹ 13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно

⁴⁰ 3.4.10.Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана;



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

Хүснэгтээс харахад 2025 оны буцаасан гүйлгээний дүн 2023 оны мөн үеэс 2.5 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Аудитын явцад “Төлбөр тооцооны мэргэжилтэн”-ээс нийт буцаасан гүйлгээний шалтгаан, нөхцөлийг тодруулахад:



- Төлбөрийн хүсэлтийн хяналтын хэсэгт анхан шатны баримт дутуу бүртгэсэн, иж бүрдэл бүрэн бус шалтгаанаар 67 хувийг,
- Хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал зөрүүтэй шалтгаанаар 28 хувийг,
- Бусад шалтгаанаар 5 хувийг буцаасан байна.

Харин дээрх онуудад нийт 929 байгууллагын 35,751.04 сая төгрөгийн 99,894 гүйлгээнд журмын дагуу залруулгын бичилт хийсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №7/

Хүснэгт №12. Залруулсан гүйлгээний мэдээлэл

№	Огноо	Байгууллагын тоо	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	2023	297	41736	10,310.35
2	2024	291	52856	15,103.39
3	2025	341	5302	10,337.29
НИЙТ		929	99894	35,751.04

Эх сурвалж: Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжээс ирүүлсэн судалгаа

Дүгнэлт: Төрийн сангийн нэгжүүд нь холбогдох эрх зүйн актыг баримтлан залруулгын гүйлгээг хийж, шаардлага хангаагүй гүйлгээг буцааж байна.

2.2.4. Төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсөв хоорондын тооцоо болон холбогдох тохируулгын тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, тайлагнаж байна уу?

Төсвийн захирагч нар жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг ТТХ-ийн 8⁴¹ дугаар зүйл, ТСҮАЖ-ын 4⁴² дэх хэсэгт заасан хугацаанд, маягтын дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр зохицуулалтыг тусгажээ.

Аудитаар дээрх эрх зүйн актуудын хэрэгжилтийн байдлыг тулган, баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- БЗД, СХД, СБД, ЧД-ийн төрийн сангийн нэгж 2024 онд ТАБ-т жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг хүргүүлэхдээ 1-5 хоног,
- БХД, БНД, БЗД, СБД, ЧД-ийн төрийн сангийн нэгж 2024, 2025 онд төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний зарцуулалтын мэдээг тайлагнаагүй,
- БГД, БЗД, БНД, НД, СБД, СХД, ХУД, ЧД болон нийслэлийн харьяа байгууллагууд 2023-2025 онд төрийн сангийн нэгжид төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хүргүүлэхдээ 25-1572 удаа хоцроосон, 14-672 мэдээг хүргүүлээгүй /Дэлгэрэнгүйг хавсралт №8/,
- Нийслэл, дүүргүүдийн төсвийн захирагч нар 2023-2025 онд тусгай сан, төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг хүргүүлэхдээ 5-12 хоног хоцроосон /Дэлгэрэнгүйг хавсралт №9/,
- Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл, Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл, Ногоон-Улаанбаатар орон сууц төслийн нэгжүүд 2023-2025 онд засгийн газрын

⁴¹ 8 дугаар зүйл. Төсвийн цаглавар

⁴² Дөрөв. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ боловсруулах



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслийн сарын гүйцэтгэлийн мэдээг хүргүүлэхдээ 8-22 удаа хоцроосон байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №10/

Энэ нь ТТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.9.2⁴³ дахь заалт, ТСҮАЖ-ын 2.8.6⁴⁴, 4.6.1⁴⁵, 4.6.1.2⁴⁶ дэх хэсэгт заасантай нийцээгүй буюу хэрэгжилт хангалтгүйг харуулж байна.

Мөн СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2⁴⁷ дахь хэсэгт заасны дагуу тухайн шатны ЗДТГ-ын дарга ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн эсэхийг тулган, баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ /Дэлгэрэнгүйг хавсралт №11/. Үүнд:

- Дүүргүүдийн ЗДТГ-ын дарга нар 2023-2025 онд 29-58 хоног,
- Нийслэлийн ЗДТГ-ын дарга 2023-2025 онд 26-37 хоног хоцроосон байна.

Харин БОНХС-ын 2014 оны А-04 дүгээр тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 4.2⁴⁸ дахь хэсгийн хэрэгжилтийг тулган, баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- БГД, НД, СХД, ХУД нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данстай бөгөөд аудитын хамрах хугацаанд журмын дагуу тайлан боловсруулж, баталгаажуулсан;
- БНД, БХД, СБД нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансийг нээлгэсэн боловч орлого, зарлага гараагүй тул тайлан гаргаагүй;
- Нийслэл, БЗД, ЧД нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансгүй байна.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжүүд холбогдох хууль, журамд заасан хугацаанд тайлан, мэдээг боловсруулан хүргүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.3. Төрийн сангийн үйл ажиллагаа, хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

⁴³ 8.9.2.төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

⁴⁴ 2.8.6.Төсвийн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зарцуулалтын мэдээг энэ журмын 29 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор төв төрийн сан болон аймаг, нийслэлийн төрийн санд хүргүүлнэ.

⁴⁵ 4.6.1.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг Төсвийн тухай хуулийн 8.8-д заасны дагуу энэ журмын 7 болон 8 дугаар хавсралтад заасан маягтаар, өглөг, авлагын мэдээг мөн журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу нэгтгэж төв төрийн санд хүргүүлнэ. Тус мэдээг боловсруулахад төрийн сангийн холбогдох системд дараах бичилтийг хийнэ:

⁴⁶ 4.6.1.2.Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслийн сарын гүйцэтгэлийн мэдээг дараа сарын 02-ны өдрийн дотор төрийн сангийн холбогдох системд бүртгэнэ;

⁴⁷ 9.2.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

⁴⁸ 4.2 Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг санхүүгийн асуудал хариуцсан нэгж тухайн оны 12 дугаар сард багтаан гаргана.



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

Төрийн сангийн зарим нэгжид дотоод хяналтын орон тоо батлагдаагүйгээс эрсдэлийн үнэлгээ болон өдөр тутмын дотоод хяналтын хэрэгжилт сул, мөн хяналт шалгалтын үр дүнг бүрэн тооцоогүй нь холбогдох хууль, журмын хэрэгжилтийг бүрэн хангаагүй, хяналтын тогтолцооны үр нөлөөг бууруулж байна. ТАБ-аас хуулийн хугацаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

2.3.1. Төрийн сангийн төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус дотоод хяналтыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу тогтмол хэрэгжүүлж, тайлан гаргаж, удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээ авч ажилласан уу?

ТТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.6⁴⁹-д зааснаар дээд шатны төрийн сангийн нэгж нь төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг ТСҮАЖ-ын 3.9.3⁵⁰ дахь хэсэгт зааснаар дотоод хяналтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон өдөр тутмын гэсэн 3 хэлбэрээр тус тус хэрэгжүүлэхээр байна.

Аудитын хугацаанд төв төрийн сангаас нийслэлийн төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Харин нийслэлийн ЗД-ын 2023 оны А/269, 2024 оны А/411, 2025 оны А/464 дүгээр захирамж, ЗДТГ-ын СХОГ-ын даргын баталсан удирдамжийг тус тус үндэслэн нийслэлийн төрийн сангаас дүүргүүдийн төрийн сангийн нэгжүүдэд дараах байдлаар төлөвлөгөөт хяналт хэрэгжүүлжээ.

Хүснэгт №13. Төрийн сангийн нэгжид дээд шатны байгууллагаас санхүүгийн дотоод хяналт хэрэгжүүлсэн байдал

№	Дүүрэг	Хяналт хэрэгжүүлсэн он			Дүн
		2023	2024	2025	
1	БГД	1	1	1	3
2	БЗД	1	1	1	3
3	БНД				-
4	БХД		1		1
5	НД		1		1
6	СБД		1		1
7	СХД		1	1	2
8	ХУД	1	1		2
9	ЧД		1		1
Нийт		3	8	3	14

Эх сурвалж: Аудитын баг

Хүснэгтээс харахад нийслэлийн төрийн сангийн нэгжээс дүүргүүдийн төрийн сангийн хэлтсүүдэд 2023 онд 33.3, 2024 онд 88.9, 2025 онд 33.3 хувьд нь санхүүгийн дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж, дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

- Цаасан суурьтай баримт бичигт эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зураагүй,
- Байгууллагуудын цалингийн гүйлгээнд холбогдох санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу,

⁴⁹ Төв төрийн сан нь аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан нь сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ.

⁵⁰ 3.9.3. Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

3.9.3.1. төлөвлөгөөт;

3.9.3.2. төлөвлөгөөт бус;

3.9.3.3. өдөр тутмын.



- Санхүүжилт, тайлагнал, төлбөр тооцооны хяналтыг хэрэгжүүлсэн ч төрийн сангийн дотоод үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Дүүргүүдийн төрийн сангийн нэгжүүдэд хийсэн нийт 14 удаагийн хяналт шалгалтын мөрөөр хүргүүлсэн тайлан, зөвлөмжийн хэрэгжилтэд эргэн хяналт тавьж, үр дүнг тооцсон эсэхийг тулган, баталгаажуулахад ХУД болон СБД тус бүр 1 удаа биелэлтийг хүргүүлсэн, бусад хугацаанд илэрсэн зөрчилд хариу арга хэмжээ авч ажилласан эсэх нь тодорхойгүй, өгсөн зөвлөмжийн биелэлтийг хүргүүлээгүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №12/

ТСҮАЖ-д заасан төлөвлөгөөт бус хяналтыг бүх түвшний төрийн сангийн нэгжүүдэд хэрэгжүүлээгүй байна.

Дээрх зөрчлүүд нь ТТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.6⁵¹, 37 дугаар зүйлийн 37.1.1⁵² дэх заалт, ТСҮАЖ-ын 3.9⁵³ дэх хэсгийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байгааг харуулж байна.

Дүгнэлт: Дүүргүүдийн төрийн сангийн нэгжүүдэд хийсэн хяналт шалгалтын үр дүнг бүрэн тооцоогүйгээс үр нөлөө багатай байна.

2.3.2. Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг зааврын дагуу үнэлсэн мөн өдөр тутмын дотоод хяналтыг бүх шатны төрийн сангийн үйл ажиллагаанд батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу тогтмол хэрэгжүүлж, тайлагнан удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан уу?

ТТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1.1-т “Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих”, ТСҮАЖ-ын 3.9.8-д “Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан албан тушаалтан жил бүрийн эхэнд төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлэх зааварт заасны дагуу үнэлж, удирдлагадаа танилцуулна” гэж заажээ.

Нийслэл, дүүргийн төрийн сангийн хэмжээнд 80 хувь нь дотоод хяналт хариуцсан албан тушаалтны орон тоогүй, 20 хувь нь 2025 онд орон тоог баталсан байна. Үүнд:

- Нийслэлийн төрийн сангийн нэгжид “Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн”, “Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн”,
- ХУД-ийн төрийн сангийн нэгжид “Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн”

Төрийн сангийн бусад 8 нэгжид “дотоод хяналт хариуцсан” албан тушаалтан байхгүйгээс дотоод үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг үнэлэх, хяналт хэрэгжүүлэх, хариу арга хэмжээ авч зөвлөмж хүргүүлэх үйл ажиллагаа доголдох зэрэг нөхцөл байдал үүссэнийг харуулж байна.

Мөн Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг үнэлж байгаа эсэх асуудлыг нягтлан шалгахад:

Нийслэлийн төрийн сангийн нэгж 2025 онд БЗД, БГД, СБД-дэд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ СС-ын 2024 оны 254 дүгээр тушаалаар баталсан “Дотоод

⁵¹ 36.6.Төв төрийн сан нь аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан нь сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ.

⁵² 37.1.1.төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих;

⁵³ 3.9.Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналт:



хяналтын заавар”-ын 3.1⁵⁴, 4.1⁵⁵, 4.2⁵⁶, 5.1⁵⁷ дэх хэсэгт заасны дагуу эрсдэлийг үнэлсэн байна.

Дүгнэлт: Дотоод хяналт хариуцсан албан тушаалтны орон тоо хангалтгүйгээс эрсдэлийн үнэлгээ, дотоод хяналтын хэрэгжилт хангалтгүй байна.

2.3.3. Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

ТТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.1⁵⁸, 69.5⁵⁹ дахь заалтад төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн хяналт, шалгалт хийх, **эрсдэлийн удирдлагаар хангахад** чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, түүний дүрмийг ЗГ батлахаар хуульчилсан байна.

ЗГ-ын 2015 оны 483 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.10⁶⁰-т “...төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагчийн үйл ажиллагаанд хяналт тавих...”, 4.11⁶¹-т “...нийслэл, дүүргийн дотоод аудитын нэгж нь ... холбогдох дотоод аудитын нэгжтэй нь зөвшилцсөний үндсэн дээр зохих журмын дагуу хяналт тавих...” гэж заасан.

Нийслэл, дүүргүүдийн дотоод аудитын алба нь 2023-2025 онд дотоод аудитын дүрмийн 7.1⁶², 7.2⁶³ дахь хэсгийг үндэслэн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа төрийн сангийн нэгжийн эрсдэлийг үнэлэх, санхүү, төсөв, төрийн сангийн үйл ажиллагааны үнэн зөв, найдвартай байдалд хяналт шалгалт хийх ажлыг тусгаагүйгээс хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Харин Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1⁶⁴, 8 дугаар зүйлийн 8.1⁶⁵-т заасны дагуу НТАГ-ын САА жил бүр Нийслэл, дүүргийн тухайн жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хуулийн хугацаанд аудит хийж, баталгаажуулан ажиллаж байна.

Дүгнэлт: Төрийн аудитын байгууллага хуулийн хугацаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

⁵⁴ 3.1 Дотоод хяналтыг дараах хууль тогтоомж, журам, зааврын хүрээнд хэрэгжүүлнэ

⁵⁵ 4.1 “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.3-т заасны дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлнэ.

⁵⁶ 4.2 Төлөвлөгөөт дотоод хяналтын төлөвлөгөө, удирдамжийг тухай оны эхний улиралд багтаан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.4, 3.9.5-д заасны дагуу эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулна.

⁵⁷ “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.8-д заасны дагуу эрсдэлийн түвшинг үнэлж, дараах байдлаар харьяа төрийн санд хүргүүлнэ.

⁵⁸ 69.1. Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

⁵⁹ 69.5. Дотоод аудитын албаны дүрмийг Засгийн газар батална.

⁶⁰ 4.10. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж, түүний эрхлэх асуудлын хүрээний төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагчийн үйл ажиллагаанд хяналт тавина.

⁶¹ 4.11. Аймаг, нийслэл, дүүргийн дотоод аудитын нэгж нь тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад холбогдох дотоод аудитын нэгжтэй нь зөвшилцсөний үндсэн дээр зохих журмын дагуу хяналт тавина.

⁶² 7.1. Дотоод аудитын нэгж нь тухайн жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөтэй байх бөгөөд төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагч батална.

⁶³ 7.2. Дотоод аудитын жилийн төлөвлөгөөнд тусгасан аудитын удирдамжийг тухайн төсвийн ерөнхийлөн захирагч батална.

⁶⁴ 6.3.1. шалгаагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

⁶⁵ 8.1. Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2026.05.21 № 02-01/3512
танай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

Таны 2026 оны 1080 дугаартай албан бичигтэй танилцлаа.

“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл” сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох саналыг хэвсрэлтаар хургүүлж байна.

Хүлээн авч, шийдвэрлэж өгнө үү.
Хэвсрэлт / хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭДИЙН
ЗАСГИЙН ХӨГЖИЛ, ДЭД БҮТЦИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН НЭГДҮГЭЭР
ОРЛОГЧ

Б.МӨНХБАТ

1726140320

Нийслэлийн Засаг даргын 2026 оны
5 дугаар сарын 21-ний өдрийн
02-01/3512 тоот албан бичгийн хэвсрэлт

“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”
сэдэвт нийцлийн аудитын тайланд хүргүүлэх санал

№	Аудитын дүгээлт	Тайлбар, Санал
1	Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйцээг бүртгэж, баталгаажуулсан, санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь хургуулсангүй зэрэг зөрчлүүд давтан гарсан байна. Дээрх зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хургуулаар шийдвэрлэв.	<p>Санхүүгийн аудитаар нийслэлийн хэмээнд 2023-2025 онд анхан шатны баримтын зөрчилтэй 22,591.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Нийт зөрчлийн 52.5 хувийг нийслэл, 47.5 хувийг 9 дүүрэг эзэлж байна.</p> <p>Нийслэлийн хувьд:</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар ажиллаж байсан Н.Наранбаатар нь 2023 оны 9 сард эзлэлийн ажилгаараа нэг гарийн шалтгаанаар гадагшаа явсан. Дээрх хугацаанд нийслэлийн Засаг даргын баталсан төсвийн сөр, улирлын хуваарь, Сангийн сайдын баталсан санхүүжилтийн зэх олгох журмд заасны дагуу төсвийн байгууллагуудын санхүүжилтийг уг журмд заасан хугацаанд олгох зайшгүй шаардлага үүссэний дагуу хэлтсийн даргад цахимаар танилцуулан тухай бүр зөвшөөрөл авсан олгож ажилласан. Улмаар хэлтсийн даргын аргын хүний зөчилгээ удааширах болсон тул цахимаар гаргасан хүсэлтийн дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/381 дугаар тушаалаар ажлаас чөлөөтөл болно. Мөн үүнээс 6 сарын дараа хотын захиргаа Яармаг нүүж арихаас өөрөөр гаргах боломжгүй байсан тул баримтыг өөхөн албагүүлж амжаагүй зөрчил гаргасан болно.</p> <p>Иймд арг тусгагчид санхүүжилтийг асуудлаас болж маягтын өг бүрдлийг дутуу орхисон зөрчил гарсан.</p> <p>Дээрх зөрчилтэй байх хугацаанаас бусад санхүүжилтийг төсвийн өрөнхийлөн захиргааны баталсан сөр, улирлын хуваарь, төрийн сангийн журмд заасан хуулийн хугацаанд батлагдсан маягтыг үнэн зөв иж бүрэн хөтөлж олгосон болно.</p> <p>Төсвийн тухай хууль болон “Төрийн сангийн үйл ажиллагааны журм”-ын хүрээнд Сангийн яамнаас хэрэгжүүлдэг Төрийн сангийн нэгдсэн дансны хүрээнд ашиглагддаг Фрайданс системийн өдөр тутмын бүх гүйцэтгэлийн мэдээлэлд тулгуурлан цахимаар нийслэлийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр нэгтгэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд хууль, журмд заасан хугацаанд хүргүүлэн нэгтгүүлдэг. Мөн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн яамнаас хэрэгжүүлдэг Э-тайлан системийг ашиглан бүх байгууллагуудын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хүлээн авч шалган нэгтгэж хуулийн хугацаанд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлж тайлагнаж ажиллаж байна.</p> <p>Улаанбаатар хотын Захиргаа нь 2023 оноос түрээсийн бүүрүүлэх, төвлөлийг сааруулах бодлогын хүрээнд үйл ажиллагаагаа Яармаг дахь нутгийн захиргааны байгууллагуудын Кансард цогцлолтоор үе шатгаар нүүлгэн шилжүүлсэн. Үүнтэй холбоотойгоор 2023 онд Засаг даргын Тамгын газар, 2024 оноос хойш ажиллагааг цахимаар хийж байрласан болно.</p> <p>Мөн төрийн сангийн үйл ажиллагааг цахимаар хийж байх хүрээнд 2023 оноос эхлэн төрийн сангийн гүйцээг цахим хэлбэрт шилжүүлж, өмнөд 10 сар тухайн дараах нөхцөл байдлын улмаас зарим тайлан, мэдээг цахимаар хүлээн авч байсан. Дээрх өрчлолт, шилжилтийн үе шаттай холбогдуулан 2023-2024 онуудад цаасан суурьтай тайлан, мэдээ хугацаа хоцрох, хуучин журмын дагуу мэдээлэл ирүүлэх, мэдээ тайлангийн маягтын зөрүү үүсэх зэрэг хүчдрэлүүд гарсан болно.</p> <p>Төсвийн тухай хууль, “Төрийн сангийн үйл ажиллагааны журм”-ын хэрэгжилтийг бүрэн хангаж, дотоод амьдралыг сайжруулан, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллана.</p> <p>Иймээс энэхүү албан шаардлагыг зөвлөмж болон өөрчлөж өгнө үү.</p>



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

№	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	Саналыг хүлээн авсан эсэх	Тайлбар
1	Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг бүртгэж баталгаажуулсан, санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь хүргүүлээгүй зөрчлүүдийг дээрх тайлбарын дагуу шалтгаан, хүндрэл бэрхшээлийн улмаас гаргасан тул зөвлөмж болгож өгнө үү	Үгүй	НЗДТГ-ын СТСХ нь 2023 оны 8-10 саруудад орон нутгийн төсвийн байгууллагуудад санхүүжилтийн эрхийг СС-ын 73 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан маягтаар олгосон боловч холбогдох эрх бүхий албан тушаалтан нь гарын үсгийг зурж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын хүчин төгөлдөр байдлыг хангаагүй. Нийт 43 удаагийн эрх олголт / Энэ нь НББТХ-ийн 13.5-д “анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно” СС-ын 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан Маягт ЗЭБ №1-тэй тус тус нийцээгүй тул шийдвэрийг хэвээр үлдээв.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актууд нь Төсвийн тухай хуультай нийцсэн боловч төрийн сангийн нэгжийн бүтэц, зохион байгуулалт нь дээрх хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасан “...дэргэд...” байх гэсэн зохицуулалттай бүрэн нийцээгүй байна.
2. Төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод зарим чиг үүргийг бүрэн тусгаагүй байна.
3. “Нийслэлийн кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам”-ыг боловсруулан баталж, мөрдүүлсэн нь сайн жишиг болжээ.
4. Төсвийн батлагдсан хуваарийг үндэслэн төв төрийн сангаас зарцуулалтын эрхийг нээж, төрийн сангийн нэгж нь холбогдох эрх зүйн актыг баримтлан төлбөр, тооцоотой холбогдох чиг үүргийг хэрэгжүүлж, шаардлагатай тохиолдолд зарим гүйлгээг буцааж байна.
5. Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг бүртгэж, баталгаажуулсан, санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь хүргүүлээгүй зэрэг зөрчлүүд давтан гарсан байна. /Дээрх зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв./
6. Төрийн сангийн зарим нэгжид дотоод хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий орон тоог батлаагүйгээс эрсдэлийн үнэлгээ болон өдөр тутмын үйл ажиллагааг бүрэн хянах боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ:

1. Монгол Улсын Засгийн газарт: Нийслэл, дүүргийн төрийн сангийн бүтэц, зохион байгуулалтыг Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасан “...дэргэд...” байх гэсэн зохицуулалтад нийцүүлж, хэрэгжилтийг хангуулах талаар уламжлах;

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИД:

1. Төрийн сангийн нэгжүүдийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг тогтмолжуулж, үр дүнд үндэслэн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГАД:

1. Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.9.8 дахь хэсгийн хэрэгжилтийг дүүргүүдийн түвшинд хангуулах арга хэмжээ авч ажиллах;
2. Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахдаа холбогдох эрх зүйн баримт бичигт заасан чиг үүргийг бүрэн тусгуулах, мөн тусгай шаардлагад нийцүүлэн мэргэшлийн шаардлагыг хангуулах талаар үе шаттай арга хэмжээ авч ажиллах;



ХАВСРАЛТ

Хавсралт №1

Дүүргүүдийн ЗДТГ-ын бүтэц баталсан захирамж /2023-2025/

№	Дүүрэг	Захирамж			СТСХ-ийн орон тоо		
		Огноо	Дугаар	Нэр	Батлагдсан орон тоо	Орон тоо	Гүйцэтгэл
1	БГД	2024.05.17	A/308	Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоо ажлын байрны жагсаалтыг шинэчлэн батлах тухай	12	11	11
		2025.05.01	A/204		12	11	11
2	БНД	2024.05.16	A/156	Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны жагсаалтыг шинэчлэн батлах тухай	8	8	8
		2025.05.01	A/148		8	8	8
3	БХД	2023.07.18	A/158	Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны жагсаалтыг шинэчлэн батлах тухай	6	6	6
		2024.06.14	A/112		6	6	6
		2025.01.06	A/47		6	5	5
4	БЗД	2023.09.21	-	Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай	13	13	13
		2024.05.20	-		14	14	14
		2025.05.01	A/29		15	15	15
5	НД	2024.07.09	A/180	Дүүргийн ЗДТГ, хороо болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах ажлын байр /албан тушаал/-ын жагсаалтыг шинэчлэн батлах тухай	9	6	6
		2025.04.10	A/93		9	6	6
6	СБД	2022.06.15	A/226	Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны жагсаалтыг шинэчлэн батлах тухай	12	10	10
		2025.05.02	A/185		12	9	9
7	СХД	2024.06.21	-	Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны жагсаалтыг шинэчлэн батлах тухай	10	10	10
		2025.04.01	-		11	11	11
8	ХУД	2023.02.17	-	Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны жагсаалтыг шинэчлэн батлах тухай	12	12	12
		2024.05.29	-		13	13	13
		2025.04.23	-		12	10	10
9	ЧД	2024.04.30	A/1057	Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны жагсаалтыг шинэчлэн батлах тухай	12	12	12
		2025.05.02	A/536		12	12	12

Эх сурвалж: Дүүргүүдийн ЗД-ын 2022-2025 оны бүтэц, орон тоо баталсан захирамжууд

Хавсралт №2

Нийслэл, дүүргийн СТСХ-т хамаарах байгууллага, тэдгээрийн данс болон гүйлгээний тоон мэдээлэл



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

№	Харьяалал	Байгууллагын тоо				Дансны тоо				Гүйлгээний тоо			
		2023	2024	2025	Дундаж	2023	2024	2025	Дундаж	2023	2024	2025	Дундаж
1	БХД	18	20	20	19	130	94	80	101	4606	6157	6398	5720
2	НД	46	47	47	47	200	153	153	169	12054	16939	16230	15074
3	БНД	40	40	41	40	165	179	134	159	21635	22370	21283	21763
4	БГД	76	80	86	81	205	224	226	218	30143	24063	31867	28691
5	СБД	79	79	80	79	237	186	186	203	29783	34709	31711	32068
6	ХУД	82	88	99	90	278	293	360	310	23815	39324	39071	34070
7	СХД	129	133	139	134	268	276	288	277	33199	50390	53469	45686
8	ЧД	78	78	79	78	173	183	181	179	43765	53688	49907	49120
9	БЗД	124	125	126	125	290	292	294	292	35936	66298	53714	51983
10	Нийслэл	78	71	68	72	282	278	281	280	44445	62519	66248	57737

Эх сурвалж: Нийслэлийн төрийн сангаас ирүүлсэн мэдээлэл

Хавсралт №3

2023-2025 онд санхүүгийн аудитаар илэрсэн эдийн засгийн ангилал зөрчсөн зөрчил

№	Тайлант он	Шалгагдагч байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Мөнгөн дүн
1	2023	Нийслэлийн онцгой байдлыг газар	Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан.	12,000,000.00
2	2023	Нийслэлийн хяналт шалгалтын газар	Зардлын зүйл ангийг эдийн засгийн ангиллын дагуу зөв бүртгэсэн эсэх, зарцуулалтыг үнэн зөв гаргасан эсэхийг тулгахад Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас бичиг хэргийн /5549.1 мянган төгрөг/, хөдөлмөр хамгааллын хэрэглэлийн зардлаас ажлын хувцас буюу бөмбөр куртик/4320.0 мянган төгрөг/ авсан байна.	9,869,100.00
3	2023	СХД-ын Цагдаагийн газар	Батлагдсан төсвийн зардлын ангиллыг зөрчиж гүйлгээ хийсэн байна.	30,069,900.00
4	2023	Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	Зардлыг эдийн засгийн ангилал зөрүүлж зарцуулсан байна.	950,000.00
5	2023	БЗД-ын Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын хэлтэс	Зардлыг эдийн засгийн ангилал зөрүүлж зарцуулсан байна.	32,378,000.00
6	2023	НД дэх Цагдаагийн хэлтэс	Зөвшөөрөгдсөн зардлын ангиллыг зөрчиж гүйлгээ хийсэн.	1,591,500.00
7	2023	БГД-ын Татварын хэлтэс	Батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн.	1,029,900.00
8	2023	ХУД-ын Прокурорын газар	Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн.	3,000,000.00
9	2023	Нийслэлийн Дотоод аудитын газар	Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрчиж, гүйлгээ хийсэн.	1,039,500.00



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

10	2024	ХУД-ын Боловсролын хэлтэс	Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн.	2,206,000.00
11	2024	ХУД-ын ЗДТГ	Батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн.	13,200,000.00
12	2024	НД-ын ИТХ	Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрчиж зардал гаргасан.	7,842,300.00
13	2024	НД-ын ЗДТГ	Батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн.	307,000.00
14	2024	СХД-ын 116 дугаар цэцэрлэг	Сургалтын зардлыг ангилал зөрүүлэн зарцуулсан	1,200,000.00
15	2024	НД-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ гаргасан.	7,815,000.00
16	2024	БНД-ын Прокурорын газар	Бараа үйлчилгээний зардлаас сургалт, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлаас хөрөнгө бэлтгэж, зардлын ангилал зөрүүлэн тайлагнасан	8,220,000.00
17	2024	НД-ын Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	НДШ-ийг цалингийн зардлаас гаргаж эдийн засгийн ангилал зөрчсөн.	572,000.00
18	2024	Нийслэлийн Амгалан амаржих газар	Төсвийн зарлагыг эдийн засгийн ангиллын дагуу тайлагнаагүй, зардал хооронд гүйлгэн хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийг устгал ариутгалын зардалд цэвэрлэгээний материалын зардлыг тусгасан.	33,222,600.00
19	2024	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрүүлж гүйлгээ хийсэн.	3,978,200.00
20	2024	СХД-ын ЗДТГ	Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан.	100,702,750.00
21	2024	СХД-ын Худалдан авах ажиллагааны алба	Эдийн засгийн засгийн ангилал зөрчсөн байна.	11,233,600.00
22	2024	Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв	Төсвийн зарлагыг эдийн засгийн ангиллын дагуу тайлагнаагүй. Түлш халаалтын зардлаас 14,0815,00.72 төгрөгийн цахилгааны зардал, шуудан холбооны зардлаас 1,400,000 төгрөгийн шатахууны зардлуудыг төсвийн зориулалтын дагуу гаргаагүй.	15,481,500.00
23	2024	ЧД-ын ЗДТГ	Батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 11,114.8 мянган төгрөгийг арга хэмжээнд зарцуулсан байна.	11,114,800.00
24	2025	БНД дэх Цагдаагийн хэлтэс	Батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас сургалтын 1,200.0 мянган төгрөгийн зардал олгосон байна.	1,200,000.00
25	2025	НД-ын ЗДТГ	Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан.	3,723,800.00
26	2025	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан байна.	3,851,000.00
27	2025	СХД-ын ИТХ	Үндсэн үйл ажиллагааны бараа үйлчилгээний зардлын эдийн засгийн ангиллаас тавилга эд хогшил худалдан авсан байна.	4,444,900.00
28	2025	БЗД-ын ЗДТГ	Батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж шуудан холбооны зардлаас 4,560.0 мянган төгрөгийг ашиглалтын зардал, түрээсийн төлбөр төлсөн байна	4,560,000.00
29	2025	СХД-ын 9 дүгээр сургууль	Эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ гаргасан байна.	5,857,200.00



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

30	2025	БНД-ын ОБХ	Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, урсгал зардлаас тавилга эд хогшил худалдан авсан байна.	6,485,500.00
31	2025	СХД-ын 107 дугаар сургууль	Эдийн засгийн ангилал зөрчиж мэдээлэл технологийн үйлчилгээний зардлаас принтерийн засвар, камер худалдан авсан	7,506,500.00
32	2025	БЗД-ын Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн ОНӨААТҮГ	Батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж албан хаагчид нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас балансын урамшуулал цалин олгосон байна.	11,183,400.00
33	2025	СХД-ын Хөгжил цогцолбор сургууль	Төсвийн тооцоолол байхгүй, тушаал шийдвэргүйгээр бараа материал худалдан авсан, эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ гаргасан байна.	11,552,000.00
34	2025	СБД-ын ИТХ	Эдийн засгийн ангилал зөрчиж зардал гаргасан.	21,189,700.00
35	2025	СХД-ын ЗДТГ	Эдийн засгийн ангилал зөрчиж гаргасан томилолтын зардал нь томилолтын удирдамж, ажлын тайлан анхан шатны баримт бүрдэл дутуу байна:	87,287,200.00
36	2025	СБД-ын ЗДТГ	Эдийн засгийн ангилал зөрчиж зардал гаргасан.	234,796,500.00
НИЙТ				712,661,350.00

Эх сурвалж: НТАГ-ын САА-ны 2023-2025 оны аудитын тайлан

Хавсралт №4

Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжийн 2023-2025 оны үйл ажиллагааны үзүүлэлтүүд

№	Харьяалал	Огноо	Байгууллагын тоо	Дансны тоо	Нийт гүйлгээний тоо
1	БХД	2023 он	18	130	4606
		2024 он	20	94	6157
		2025 он	20	80	6398
НИЙТ			58	304	17161
2	БНД	2023 он	40	165	21635
		2024 он	40	179	22370
		2025 он	41	134	21283
НИЙТ			121	478	65288
3	БГД	2023 он	76	205	30143
		2024 он	80	224	24063
		2025 он	86	226	31867
НИЙТ			242	655	86073
4	БЗД	2023 он	124	290	35936
		2024 он	125	292	66298
		2025 он	126	294	53714
НИЙТ			375	876	155948
5	НД	2023 он	46	200	12054
		2024 он	47	153	16939
		2025 он	47	153	16230
НИЙТ			140	506	45223
6	СХД	2023 он	129	268	33199
		2024 он	133	276	50390
		2025 он	139	288	53469



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

НИЙТ			401	832	137058
7	СБД	2023 он	79	237	29783
		2024 он	79	186	34709
		2025 он	80	186	31711
НИЙТ			238	609	96203
8	ХУД	2023 он	82	278	23815
		2024 он	88	293	39324
		2025 он	99	360	39071
НИЙТ			269	931	102210
9	ЧД	2023 он	78	173	43765
		2024 он	78	183	53688
		2025 он	79	181	49907
НИЙТ			235	537	147360
10	Нийслэл	2023 он	78	282	44445
		2024 он	71	278	62519
		2025 он	68	265	66248
НИЙТ			217	841	173212
НИЙТ ДҮН			2296	6553	1025736

Эх сурвалж: Нийслэл, дүүргийн төрийн сангаас ирүүлсэн судалгаа

Хавсралт №5

Санхүүгийн аудитаар 2023-2025 онд илэрсэн анхан шатны баримтын зөрчлийн нэгтгэл

№	Харьяалал	Байгууллагын тоо	Мөнгөн дүн
1	БНД	24	1,388,589,711.62
2	БХД	22	146,783,090.00
3	БГД	48	810,756,475.66
4	БЗД	99	1,196,781,474.23
5	НД	33	613,440,900.00
6	СХД	65	1,187,627,745.06
7	СБД	66	1,346,499,101.77
8	ХУД	72	2,747,354,896.45
9	ЧД	97	1,300,605,018.00
10	Нийслэл	137	11,852,732,246.92
НИЙТ		664	22,591,170,659.71

Эх сурвалж: НТАГ-ын САА-ны 2023-2025 оны аудитын тайлан

Хавсралт №6

Нийслэл, дүүргийн төрийн сангийн нэгжээс буцаасан гүйлгээ

№	Харьяалал	Огноо	Байгууллагын тоо	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн /сая.төг/
1	БГД	2023 он	75	1652	9,180.70



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

		2024 он	80	1683	12,528.68
		2025 он	85	2365	22,834.21
НИЙТ			240	5700	44,543.60
2	НД	2023 он	42	1240	4,260.78
		2024 он	40	892	5,192.98
		2025 он	42	858	5,227.57
НИЙТ			124	2990	14,681.34
3	БХД	2023 он	19	393	837.78
		2024 он	18	203	629.11
		2025 он	16	161	1,051.56
НИЙТ			53	757	2,518.45
4	СХД	2023 он	123	2801	11,991.24
		2024 он	124	1857	20,152.39
		2025 он	128	3110	33,341.15
НИЙТ			375	7768	65,484.78
5	БЗД	2023 он	119	2983	44,094.08
		2024 он	125	3934	43,507.66
		2025 он	124	4371	58,446.43
НИЙТ			368	11288	146,048.18
6	СБД	2023 он	71	3,628	31,235.97
		2024 он	72	4,193	105,060.49
		2025 он	73	4,111	38,655.05
НИЙТ			216	11932	174,951.95
7	ЧД	2023 он	79	2636	18,064.03
		2024 он	79	3423	30,552.59
		2025 он	78	2518	24,134.64
НИЙТ			236	8577	72,751.27
8	ХУД	2023 он	84	3439	24,261.05
		2024 он	87	2939	27,844.47
		2025 он	95	3654	26,378.56
НИЙТ			266	10032	78,484.08
9	БГД	2023 он	36	1111	2,591.23
		2024 он	36	954	5,894.71
		2025 он	37	1131	6,228.92
НИЙТ			109	3196	14,714.86
10	Нийслэл	2023 он	71	4757	23,766.20
		2024 он	69	3001	95,047.03
		2025 он	67	3756	209,931.24
НИЙТ			207	11514	328,744.47
НИЙТ ДҮН			2194	73754	942,922.97

Эх сурвалж: Нийслэл, дүүргийн төрийн сангаас ирүүлсэн судалгаа



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

Хавсралт №7

**Нийслэл, дүүргийн төрийн сангийн
нэгжээс залруулсан гүйлгээ**

№	Харьяалал	Огноо	Байгууллагын тоо	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн /сая.төг/
1	БХД	2023 он	18	44	34.90
		2024 он	20	71	167.73
		2025 он	20	69	88.97
НИЙТ			58	184	291.60
2	БНД	2023 он	22	42	10.49
		2024 он	21	40	8.47
		2025 он	19	30	6.49
НИЙТ			62	112	25.44
3	БГД	2023 он	-	-	-
		2024 он	3	6	143.08
		2025 он	4	6	415.49
НИЙТ			7	12	558.56
4	БЗД	2023 он	69	69	536.38
		2024 он	77	77	7,054.99
		2025 он	80	80	3,988.53
НИЙТ			226	226	11,579.90
5	НД	2023 он	8	122	0.56
		2024 он	16	194	0.25
		2025 он	9	217	0.88
НИЙТ			33	533	1.69
6	СХД	2023 он	7	7	30.06
		2024 он	3	3	30.01
		2025 он	19	21	75.63
НИЙТ			29	31	135.69
7	СБД	2023 он	72	150	1,278.02
		2024 он	72	162	1,012.89
		2025 он	73	126	2,053.47
НИЙТ			217	438	4,344.38
8	ХУД	2023 он	7	7	87.76
		2024 он	4	5	385.54
		2025 он	4	4	233.84
НИЙТ			15	16	707.14
9	ЧД	2023 он	76	347	1,189.30
		2024 он	65	374	2,603.63
		2025 он	91	706	1,745.63
НИЙТ			232	1427	707.14
10	Нийслэл	2023 он	18	1586	7,142.89



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

	2024 он	10	1574	3,696.82
	2025 он	22	224	1,728.37
НИЙТ		50	3384	707.14
НИЙТ ДҮН		929	6363	35,751.04

Эх сурвалж: Нийслэл, дүүргийн төрийн сангаас ирүүлсэн судалгаа

Хавсралт №8

Нийслэл, дүүргийн төсвийн шууд захирагч нар 2023-2025 оны гүйцэтгэлийн мэдээг төсвийн захирагч нарт хүргүүлсэн байдал /сараар/

№	Харьяалал	Илгээвэл зохих	Хугацаандаа	Хугацаа хоцроосон	Баталгаажуулж, хүргүүлээгүй
1	БХД	216	167	49	0
2	БНД	900	510	376	14
3	БГД	2880	1746	1057	77
4	БЗД	3648	3623	25	0
5	НД	1233	700	533	0
6	СХД	3948	2657	1291	0
7	СБД	2436	192	1572	672
8	ХУД	2984	1563	1097	324
9	ЧД	2700	1879	798	23
10	Нийслэл	1736	1039	695	2
НИЙТ		22681	14076	7493	1112

Эх сурвалж: Нийслэл, дүүргийн төрийн сангаас ирүүлсэн судалгаа

Хавсралт №9

Нийслэл, дүүргийн төсвийн захирагч нар 2023-2025 онд дээд шатны байгууллагад гүйцэтгэлийн мэдээг хүргүүлсэн байдал /сараар/

№	Харьяалал	Илгээвэл зохих	Хугацаандаа	Хугацаа хоцроосон
1	БХД	36	29	7
2	БНД	36	27	9
3	БГД	36	29	7
4	БЗД	36	26	10
5	НД	36	31	5
6	СХД	36	28	8
7	СБД	36	28	8
8	ХУД	36	26	10
9	ЧД	36	24	12
10	Нийслэл	36	27	9
НИЙТ		360	275	85

Эх сурвалж: Нийслэл, дүүргийн төрийн сангаас ирүүлсэн судалгаа

Хавсралт №10

Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслийн гүйцэтгэлийн мэдээг хүргүүлсэн байдал /сараар/



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

№	Харьяалал	Төслийн нэр	Системийн нэр	Огноо	Тайлан		
					Ирүүлбэл зохих тоо	Ирүүлсэн тоо	Ирүүлээгүй тоо
1	Улаанбаатар хотын Нэгдсэн төсөл	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл	Одамис	2023	36	12	9
2	Нэгдсэн төсөл		Одамис	2024		12	
3	Хэрэгжүүлэх нэгж		Одамис	2025		3	
НИЙТ							
4	Нийслэлийн орон сууцны бодлогын газар	Баянголын амын орлогод нийцсэн орон сууц төсөл	-	2025	24	9	12
5			-	2026		3	
НИЙТ							
6	Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ	Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төсөл	-	2024	24	1	22
7			-	2025		1	
НИЙТ							
8	Улаанбаатар хотын Нэгдсэн төсөл	УБ хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл	Одамис	2023	36	12	-
9			Одамис	2024		12	
10			Одамис	2025		12	
НИЙТ							
11	Улаанбаатар хотын Нэгдсэн төсөл	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	ERP	2023	36	9	12
12			ERP	2024		6	
13			ERP	2025		9	
НИЙТ							
14	Улаанбаатар хотын Нэгдсэн төсөл	Ногоон-Улаанбаатар орон сууц төсөл	-	2025	12	4	8

Эх сурвалж: Нийслэл, дүүргийн төрийн сангаас ирүүлсэн судалгаа

Хавсралт №11

Нийслэл, дүүргийн төсвийн захирагч нар 2023-2025 онд ОНХС-ын хөрөнгөөр санхүүжиж буй ТАХ-ний хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад хүргүүлсэн байдал /хоногоор/

№	Харьяалал	Тайланг хүргүүлэхдээ хоцроосон хоног			Нийт
		2023	2024	2025	
1	БХД	19	23	-	42
2	БНД	5	24	-	29
3	БГД	27	24	2	53
4	БЗД	-	34	4	38
5	НД	21	23	-	44
6	СХД	26	24	2	52
7	СБД	20	38	-	58
8	ХУД	22	24	-	46
9	ЧД	25	24	1	50
10	Нийслэл	35	37	26	98

Эх сурвалж: Нийслэл, дүүргийн төрийн сангаас ирүүлсэн судалгаа

Хавсралт №12

Төрийн сангийн нэгжүүдээс 2023-2025 онд хяналт, шалгалтын биелэлтийг хүргүүлсэн байдал

№	Харьяалал	Биелэлт хүргүүлэх хугацаа
---	-----------	---------------------------



“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”

		2023 он	Хүргүүлсэн эсэх	2024 он	Хүргүүлсэн эсэх	2025 он	Хүргүүлсэн эсэх
1	БГД	2023.11.10	Үгүй	2024.12.01	Үгүй	2026 оны I улирал	Үгүй
2	БЗД	2023.12.01	Үгүй	-	-	-	-
3	БХД	-	-	2024.09.01	Үгүй	-	-
4	НД	-	-	2024.09.01	Үгүй	-	-
5	СБД	-	-	2024.09.01	Үгүй	2026 оны I улирал	Тийм
6	СХД	2023.12.01	Үгүй	2024.10.01	Үгүй	-	-
7	ХУД	-	-	2024.09.01	Тийм	-	-
8	ЧД	-	-	2024.09.01	Үгүй	-	-

Эх сурвалж: Нийслэл, дүүргийн төрийн сангаас ирүүлсэн мэдээлэл